



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 08 сар | Дугаар 21

ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл
- 4–5 Зохицуулалтын мэдээ
- 6 Үнэт цаасны хил дамнасан бүртгэл, арилжааны журмуудыг шинэчлэн баталлаа
- 7 Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журмын талаар
- 8–9 Финтек ба регтек
- 10–14 Судлаачийн индэр
- 15 “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ
- 16 Санхүүгийн боловсрол
- 17 Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах
- 18–19 Аливаа компанийн хэтийн хөгжилд эергээр нөлөөлөх
- 20–23 Зах зээлийн мэдээ
- 24–25 2020 оны 7-р сарын бүс нутгийн эдийн засгийн мэдээ
- 26 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс
- 27 Санхүүгийн зах зээлийн сарын тойм 7-р сар

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976-51-264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ҮНЭТ ЦААСНЫ ХИЛ ДАМНАСАН БҮРТГЭЛ, АРИЛЖААНЫ ЖУРМУУДЫГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА



Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга **С.Цэрэндаш**

Саяхан болсон Санхүүгийн зохицуулах хорооны хуралдаанаар давхар бүртгэл, хадгаламжийн бичигтэй холбоотой журмуудад өөрчлөлт орсон талаар мэдээлэл өгнө үү?

Санхүүгийн зохицуулах хорооноос анх 2014 онд “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”, 2018 онд “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ыг баталж мөрдүүлж байсан. Гэвч эдгээр журмуудын хүрээнд зохицуулж байсан харилцааг хууль тогтоомж, олон улсын жишигт нийцүүлэх, зах зээлийн хэрэгцээ шаардлагад уялдуулан шинэчлэх шаардлага гарсан тул холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж шинэчлэн батлаад байна.

Яг ямар өөрчлөлт орсон талаар дурдана уу?

Журмууд батлагдсанаас хойших хугацаанд Канад Улсын Торонтогийн хөрөнгийн бирж дээр бүртгүүлсэн “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” Монголын хөрөнгийн бирж дээр давхар бүртгүүлж, энэ төрлийн анхны бүтээгдэхүүн гарсан. Энэхүү анхны кейс дээр зарим нэг эргэж харах, засаж сайжруулах шаардлагатай зүйлүүд гарч ирсэн. Ингээд холбогдох мэргэжлийн байгууллагууд, зах зээлд оролцогчдоосоо саналыг нь аван, хэлэлцүүлэг хийсний үр

дүнд бидний хэлж заншаад байгаа давхар бүртгэлийн журамд компанийн хоёр өөр бирж дээр бүртгэлтэй байгаа хувьцаа хоорондоо хөрвөдөг болох зэрэг бусад шаардлагатай зохицуулалтуудыг тусгаж өгсөн.

Үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулснаар гадаад улсын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй манай улсын томоохон компаниуд хувьцаагаа давхар арилжаалах, уг ажиллагаатай холбоотой бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэх, дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг дорвитой хэмжээнд нэмэгдүүлэх, хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах, бирж хоорондын хувьцааны хөрвүүлэлтийг хийх зэрэг томоохон зохицуулалтын өөрчлөлтийг бий болгох боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага болон хөрөнгө оруулагчдын дунд давхар бүртгэл, бирж хоорондын хувьцааны арилжаатай холбоотой үүсээд байсан хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэсэн чухал бодлогын алхам болсон.

Харин хадгаламжийн бичгийн журмыг Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн хуулиас давсан зохицуулалтуудыг байхгүй болгох, Монгол Улсад хадгаламжийн бичиг гаргагчид тавигдах нөхцөл, шаардлага, үүрэг хариуцлага болон хадгаламжийн бичгийг гаргах бүртгүүлэх дараалал, үе шат, хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэхтэй холбоотой харилцааг олон улсын зарчимд нийцүүлэх зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан. Түүнчлэн энэхүү журмаар зохицуулах хязгаарыг зөвхөн гадаад улсын хуулийн этгээд Монгол Улсад хадгаламжийн бичиг гаргахтай холбоотой харилцааг зохицуулахаар баталсан байгаа. Монгол Улсын компаниуд гадаад улсад хадгаламжийн бичиг гаргах харилцаа нь тухайн орныхоо зохицуулалтын хүрээнд зохицуулагдана.

Ерөнхийдөө хоёр журмыг өөрчлөхдөө зах зээлийн бодит нөхцөл байдалд нь уялдуулах, олон улсын зарчимд нийцүүлэх чиглэлд анхаарч, түүнчлэн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагуудын саналыг авч холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.

Үргэлжлэл 6-р нүүрт >>

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО

Манай улсын хувьд 1934 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 33-р хурлын тогтоолоор Улсын аюулаас хамгаалах газар нэрийн дор анхны даатгалын байгууллага үүсгэн байгуулагдаж, улмаар Монгол улс дэлхий нийтийн нийтлэг жишгээр зах зээлийн харилцаанд шилжин орсноор 1990 онд Засгийн газрын шийдвэрээр Улсын даатгалын ерөнхий газрыг Сангийн яамны харьяалаас гарган өөрчлөн зохион байгуулж, “Монгол даатгал” төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулсан ба мөн үед арилжааны даатгалын компаниуд байгуулагдах суурь тавигдсан юм.



Даатгалын зохицуулалтын үндсэн зорилго нь даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах явдал юм. Үүний нөгөө талд даатгагчийн зүгээс даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, үүний тулд тухайн даатгагч төлбөрийн чадвартай байх шаардлагатай. Даатгалын зохицуулалтад даатгалын компани, даатгалын мэргэжлийн оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, тэдний төлбөрийн чадварын байдалд байнгын хяналт тавих, бүтээгдэхүүн борлуулалтын болон зах зээлийн зохистой харилцааг төлөвшүүлэх, зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч, даатгалын салбарын эрх зүйн орчин дараах байдлаар бүрэлдэн бий болсон. Үүнд:

- Даатгалын тухай хууль 1997 онд батлагдаж, 2004 онд шинэчлэн найруулсан;

/арилжааны даатгалын харилцааг зохицуулсан анхны хууль батлагдав./

- Даатгалын мэргэжлийн оролцогчийн

тухай хууль 2004 онд батлагдсан;

/даатгалын мэргэжлийн оролцогчдын хяналт, зохицуулалтыг тодорхойлж, тэдгээрийн эрх зүйн орчныг сайжруулахад тодорхой хувь нэмрийг оруулж эхлэв./

- Жолоочийн даатгалын тухай хууль 2011 онд батлагдсан; /жолоочийн хариуцлагыг заавал даатгах даатгалын тогтолцоог нэвтрүүлэв./
- Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 онд батлагдсан.

/валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилго бүхий “Үндэсний давхар даатгал” ХК (ХААДК) төрийн өмчит хувьцаат компани байгуулагдав./



Ийнхүү даатгалын салбарын хууль эрх зүйн орчин түүхэн явцад шинэчлэгдэж, сайжирсаар одоогийн байдлаар даатгалын үйл ажиллагаа нь Иргэний хууль (даатгалын гэрээний харилцаа), Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, бусад даатгалын үйл ажиллагааг зохицуулах заалт бүхий 11 хуулийн хүрээнд зохицуулагдаж байна.

Мөн Хороо нь хуулиар олгосон эрх, үүргийн хүрээнд Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм” болон бусад холбогдох журам, зааврын хүрээнд даатгалын үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавьж байна.

Монгол Улсад даатгалын зах зээл хөгжихийн хэрээр дээр дурдсан даатгалын салбарын

хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах цаг үетэй нь нийцүүлэх шаардлага үүсэж байна. Жишээлбэл, Олон улсын жишгээс харвал даатгагчид нь хөрөнгийн зах зээлийн томоохон хөрөнгө оруулагчид байдаг учир даатгалын нөөц сангийн байршуулалт, хөрөнгө оруулалт зэрэгт баримтлах зарчим, шаардлагуудыг хууль журамд шинэчлэн тусгах, давхар даатгалын хураамжийн орлогын ихэнх хувийг гадаадын давхар даатгагчид эзэлдэг тул дотоодын даатгагч нарыг бэхжүүлэх, бодлогоор дэмжих, техник технологийн хөгжил, даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг даатгуулагчид ойртуулах зардлыг бууруулах, иргэд аж ахуй нэгжийн даатгалд хамрагдалт сул хангалтгүй түвшинд байгаа тул даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах тогтолцоог сайжруулах, иргэдийн даатгалын боловсролыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030”, “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 80, 81, 83–т “Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж даатгалын салбарын өнөөгийн байдал, хөгжлийн хандлага, зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн уг зах зээлд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, даатгалын нэр төрөл, бүтээгдэхүүний ангилал, тэдгээртэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгах” гэж заасан дээд газраас боловсруулсан бодлогын баримт бичгүүдийн хүрээнд 2018 оноос Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар Сангийн яам болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөлтэй хамтарсан ажлын хэсэг байгуулан ажилласан бөгөөд одоогийн байдлаар дээрх хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын төсөл батлагдаад байна.

Хороо нь хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Олон улсын зохицуулалтын байгууллагуудын бодлого зохицуулалтын орчин болон дотоодын даатгалын зах зээлийн хөгжил дэвшил, хурдтай нь нийцүүлэн тухай бүр холбогдох журам, заавруудыг шинэчлэн боловсруулах,

сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байна. Үүнээс онцолбол “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам”–ыг шинэчлэн найруулж Хорооны 2020 оны 114 дүгээр тогтоолоор “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”–ыг баталсан. Энэхүү журам хэрэгжиж эхэлснээр даатгалын зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй болж, мөрдөн хэвших, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэх, даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа илүү ёс зүйтэй, шударга өрсөлдөөнтэй явагдах, даатгуулагч олон нийтийн даатгалд итгэх итгэл нэмэгдэн даатгалын хамрагдалт өсөх зэрэг ач холбогдолтой юм.

Дээр дурдсан даатгалын салбарын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, журам, заавруудыг сайжруулах, шинэчлэн боловсруулах ажлуудаас гадна Хороо нь даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээнүүдийг дараах 4 үндсэн чиглэлээр авч хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

I. Олон тулгуурт даатгалын салбарын тогтолцоог бий болгох

- Урт хугацааны буюу амьдралын даатгалыг дэмжих хүрээнд Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах болон Хувийн тэтгэврийн даатгалын тухай хуулийн төслийг боловсруулахад идэвхтэй хамтран ажиллах;
- Ипотекийн даатгалын журмын хэрэгжилтийг хангуулан, иргэдийн урт хугацааны даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх;
- Даатгалын хураамжийн зохистой хувийг дотоодод үлдээн, валютын гадагшлах урсгалыг бууруулах хүрээнд дотоодын давхар даатгагчийг дэмжих эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох, хам даатгалыг зохицуулалтын хүрээнд дэмжих.

II. Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх

- Олон улсын жишигт нийцүүлэн салбарын хууль тогтоомжуудыг сайжруулан, шинэчлэх;
- Эрсдэлд суурилсан хөрөнгө, төлбөрийн чадвар, эрсдэлд суурилсан хяналт шалгалтад шилжих ажлыг эрчимжүүлж,

туршилтаар хэрэгжиж буй журам зааврыг боловсронгуй болгох;

- Даатгалын мэргэжлийн холбоод, хүний нөөцийг чадавхжуулах, Мэдээллийн нэгдсэн санг бий болгох чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлж, эрх зүйн зохицуулалтаар дэмжих.

III. Даатгалын үйлчилгээний чанар, хүртээмж, хамрагдалтыг нэмэгдүүлэх

- Зарим салбарын хуулиудад тусгагдсан заавал даатгалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт, зохицуулалтыг сайжруулах;
- Иргэд, олон нийтийн даатгалын суурь боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
- Хүртээмжтэй даатгалын үр шимийг нэмэгдүүлэх зорилгоор хяналт, зохицуулалтыг сайжруулах;
- Компанийн засаглал, мэдээллийн ил тод байдлыг дээшлүүлэх чиглэлээр хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох;
- Мэдээллийн технологийг ашиглан даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хамрагдалтыг нэмэгдүүлэх хүрээнд зохицуулалтыг сайжруулах.

IV. Хөрөнгө оруулалтыг дэмжих

- Даатгалын компанийн хөрөнгийг хувьцаа, бонд болон бусад хөрөнгө оруулалтад байршуулах зохицуулалтыг уян хатан болгох талаар судалж, санал боловсруулах;
- Даатгалын компаниуд нээлттэй хувьцаат компани болохыг бодлогоор дэмжих;
- Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг даатгалын зах зээлээс өгөөж хүртэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулах;
- Даатгалын компаниудын гадаад хамтын ажиллагаа, гадаад зах зээлээс хөрөнгө татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 17–г даатгалын компаниудад нэвтрүүлэх ажлыг Сангийн яамтай хамтран эхлүүлэх.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН СОНГУУЛТ ГИШҮҮДЭД СЕРТИФИКАТ ОЛГОХ СУРГАЛТ БОЛЛОО



Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1.12-т “ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх” гэж заасан нийтлэг шаардлагын дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос Хороотой хамтран сургалтыг зохион байгуулдаг.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсантай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс уг сургалт завсарлаад байсан бол хөл хорионы дэглэмд тохируулан цөөн тооны оролцогчтойгоор 7 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд зохион байгуулж, ХЗХ-дын гүйцэтгэх захирлууд хамрагдан сертификатаа гардан авлаа.

Сургалтын агуулгад хадгаламж зээлийн хоршооны онцлог, өнөөгийн байдал, суурь зарчмууд, хяналтын зөвлөл, тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага, ёс зүй, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, зээлийн мэдээллийн сан, Мөнгө угаах болон терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, комплайнс зэрэг сэдвүүд багтсан.

Журамд заасны дагуу нийт хадгаламж, зээлийн хоршоодын сонгуульт гишүүд болон гүйцэтгэх удирдлагууд тус сургалтад хамрагдах шаардлагатай бөгөөд нийт 207 сонгуульт гишүүд, гүйцэтгэх захирал хамрагдаад байна

НИЙТ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДҮҮДИЙН ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын стандартыг дагаж биелүүлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) стратегийн дутагдалтай улс орны жагсаалтаас Монгол Улсыг гаргах, МУТСТ чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох төрийн байгууллагууд онцгой анхаарал хандуулж байна.

Сайжруулах шаардлагатай ажлын хүрээнд эцсийн өмчлөгчийг бүртгэх үйл ажиллагаа Татварын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсантай холбогдуулан 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн этгээд нь тухайн хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэж заасны дагуу бүртгэх ажил үргэлжилж байна.

Дээрх үйл ажиллагааны зорилго нь хуулийн этгээдээр дамжуулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, татвараас зайлсхийх гэмт хэрэгт холбогдох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Эцсийн өмчлөгчийг бүртгэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 10.00–15.00 цагийн хооронд Хорооны зохицуулалтын хүрээнд хамаарагдах санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдүүдийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг бүртгүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт, бичиг шаардлагатай. Үүнд:

- “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл /УБ-12 маягт/” (<https://www.legalinfo.mn/annex/details/10679?lawid=15105>);
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
- Хуулийн этгээдийн гэрчилгээ, тамга.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОЙМ ТАНИЛЦУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 12:00 цагт хэвлэлийн бага хурал зохион байгуулан санхүүгийн салбарын 2020 оны эхний хагас жилийн тойм, хөрөнгийн зах зээл дээр хийгдэж буй онцлох ажлууд болон мөнгө угаах болон терроризмтой тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй арга



хэмжээнүүдийн талаар товч танилцуулж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариуллаа.



Санхүүгийн зохицуулах хороо нь зохицуулалт хяналтынхаа чиг үүргийн хүрээнд 2020 оны хагас жилийн байдлаар нийт 2854 зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллалаа. Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд ФАТФ-ын 2019 оны 10 дугаар сарын



ээлжит хурлаар Монгол Улсыг МУТСТ стратегийн дутагдалтай улс орны жагсаалт буюу “Саарал жагсаалт”-д оруулж, 4 шууд хэрэгжилт 6 ажлын хүрээнд 2021 он хүртэл хийж хэрэгжүүлэх ажлын даалгавар өгсөн. Монгол улс нийт 2 удаагийн явцын тайлан болон Хамтарсан бүлэгтэй уулзсаны үр дүнд өгөгдсөн үүргүүдийн ихэнхийг биелүүлсэн үнэлгээ авч “Саарал жагсаалтаас” гарах нөхцөл бүрдсэн бөгөөд Хамтарсан бүлэг Монгол Улсад ирж газар дээрх хяналт шалгалт хийснээр эцсийн үнэлгээ гарч ФАТФ-ын дараагийн ээлжит хурлаар шийдвэрлэгдсэний дараа МУТСТ стратегийн дутагдалтай улс орны жагсаалтаар гарах боломжтой болох юм.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орсноор Хорооны тусгай зөвшөөрөлтэй зохицуулалтын салбарт шинээр үл хөдлөх хөрөнгө зуучлал болон үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч этгээдийн үйл ажиллагаа хамаарах болсонтой холбогдуулан шинээр холбогдох журмуудыг батлан ажиллаж, 103 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 275 хувь хүн, хуулийн этгээд тусгай зөвшөөрлийг олгож, бүртгэлжүүлээд байна.



БАЙР СУУРЬ

ҮНЭТ ЦААСНЫ ХИЛ ДАМНАСАН БҮРТГЭЛ, АРИЛЖААНЫ ЖУРМУУДЫГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

Хоёр өөр бирж дээр бүртгэлтэй байгаа хувьцаа хоорондоо хөрвөх гэдгийг илүү дэлгэрэнгүй тайлбарлаж өгөөч. Жишээ нь одоо гарчихсан байгаа “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн хувьцааг яаж хөрвүүлэх вэ?

Хөрвүүлэх боломжтой болно гэдэг нь Монгол Улсын хөрөнгийн бирж дээр тус компанийн хувьцаа эзэмшигч өөрийн хувьцаагаа Канадын хөрөнгийн бирж рүү шилжүүлж, тус улсад өмчилж, арилжаалах боломжтой, мөн эсрэгээрээ Канад улсын хөрөнгийн бирж дээрх хувьцаа эзэмшигч манай улсын хөрөнгийн бирж рүү шилжүүлж, өмчилж, арилжаалах боломжтой болно гэсэн үг.

Өмнө нь нэг компанийн хувьцааны үнэлгээ хоёр өөр бирж дээр харилцан адилгүй тогтдог, зах зээлийн зарчмаар бодит үнэлгээ тогтох боломжгүй байсан бол хоёр биржийн хооронд хувьцаа хөрвөдөг болсноор хувьцааны зах зээлийн үнэлгээний зөрүү арилах суурь бий болж байгаа юм.

Хэрэв Монголын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшиж байгаа иргэд хувьцаагаа гадаадын хөрөнгийн бирж рүү нь хөрвүүлж гэвэл “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК/ҮЦТХТ/-аар дамжуулан хийх буюу хөрвүүлэх хүсэлтээ тус байгууллагад өгнө. ҮЦТХТ нь гадаадын бирж дээр тухайн компанийн хувьцааны бүртгэлийг хариуцсан байгууллагад мэдэгдэж нэгэн зэрэг хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулдаг. Үүний дараа иргэд тус гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үнэт цаасны дансаа нээлгэж тухайн зах зээл дээр хувьцаагаа өмчлөх, арилжаалах эрх нь нээгдэнэ.

Тус журмын дагуу ҮЦТХТ нь давхар бүртгэгдсэн компани, гадаад улсад тухайн компанийн хувьцааны бүртгэлийг хариуцсан байгууллагатай хоёр зах зээл хооронд хөрвүүлэх харилцааг зохицуулах гурван талт гэрээ байгуулах шаардлагатай. Тус гэрээний

хүрээнд хөрвүүлэх ажиллагаа явагдах учиртай юм.

Өөрөөр хэлбэл ҮЦТХТ нь одоо байгаа “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн хувьцааг Торонтогийн хөрөнгийн бирж рүү хөрвүүлэхийн тулд тус компани, гадаад улсын бүртгэлийн байгууллагатай гэрээгээ байгуулах шаардлагатай, мөн бусад хөрөнгийн биржүүд рүү хөрвүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс бусад орны энэ чиглэлээр хамтран ажиллах байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох шаардлагатай байгааг энд дурдах нь зүйтэй байх.

Давхар бүртгүүлэх сонирхлоо илэрхийлсэн компаниуд одоогоор байна уу?

Хэдийгээр журмууд маань батлагдаад тодорхой хугацаа өнгөрөөд байгаа ч энэхүү хил дамнан 2 бирж дээр бүртгэгдэх бүтээгдэхүүн хараахан хөгжиж амжаагүй байна. Гэсэн хэдий ч практик дээр 1 компани амжилттай гарсан байгаа нь өөр бусад компаниудад боломж бий гэдгийг харуулж байна. Мөн бид гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилждаг Монгол компаниуд эх орондоо давхар бүртгүүлэх боломжтой гэж харж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг боловч бусад орны томоохон биржүүд дээр хувьцаа нь арилжаалагддаг бидний одоогоор мэдэж буйгаар 40 компани байдаг бөгөөд тэдгээрийг дотоодын зах зээлд давхар бүртгэгдэх, эсхүл хадгаламжийн бичгээ гаргахад энэхүү 2 журам маань гол мөрдөгдөх журмууд нь юм.

Компани хадгаламжийн бичиг гаргах нь давхар бүртгүүлэхээс ямар ялгаатай вэ?

Хадгаламжийн бичиг нь аливаа нэг орны хөрөнгийн биржид бүртгэлтэй компани хувьцаан дээрээ суурилсан бүтээгдэхүүнийг бусад орны хөрөнгийн бирж дээр гаргах замаар урт хугацааны нэмэлт санхүүжилт татах, компанийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлд нэвтрэх, хувьцааны хөрвөх

чадварыг сайжруулах зэрэг давуу талуудыг олгодог. Нөгөө талдаа гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааг хямд зардлаар шууд худалдан авах боломж бололцоог олгодог, олон улсад өргөн хэрэглэгддэг бүтээгдэхүүн юм.

Хадгаламжийн бичиг гаргахад анхаарах асуудал?

Монгол Улсын хөрөнгийн биржид хадгаламжийн бичиг гаргах компани тухайн хувьцаа нь бүртгэлтэй байгаа орны мэргэжлийн байгууллагад хандах, эсвэл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй кастодиан банктай холбогдож хүсэлт гаргах бөгөөд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Кастодиан банк эсвэл түүнтэй гэрээ байгуулсан тухайн орны мэргэжлийн байгууллагаас СЗХ-нд хүсэлт гаргаж, хадгаламжийн бичгээ бүртгүүлсний үндсэн дээр олон нийтэд хадгаламжийн бичиг гаргах боломжтой болно.

Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалтыг маш тодорхой болгож бодит нөхцөл байдалд нь уялдуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Одоо салбарын мэргэжлийн байгууллагууд, ялангуяа кастодиан банкууд энэхүү журмын хүрээнд бүтээгдэхүүн гаргах чиглэлээр идэвхтэй ажиллах шаардлагатай байна.

Мөн дээрх хоёр журам батлагдсанаар хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын үүрэг, хариуцлага нэмэгдэж, өөрсдийн холбогдох дүрэм, журамдаа холбогдох өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай.

Ярилцлага өгсөнд баярлалаа.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙГӨӨР ЭРХЛЭХ ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРМЫН ТАЛААР

Санхүүгийн зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд Хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ыг батлан, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг.

Хороо дараах хуулийн этгээдэд тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина:

- Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан;
- хуулийн этгээдийн хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг эсхүл, эзэмших хүсэлт гаргасан этгээд, хувьцааны дийлэнх хэсгийг, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдүүд хамтран өмчилж байгаа этгээд;
- хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний нийт хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, Хорооноос шаардлагатай гэж үзсэн эрх бүхий албан тушаалтан.

Дараах шалгууруудыг хангасан хуулийн этгээдийг тохиромжтой этгээд гэж үзнэ:

- санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадвартай байх /энэ шалгуур нь хэвийнээс бусад зээлийн өрийн үлдэгдэлгүй байх, санхүүгийн хүндрэлд орж төлбөрийн чадваргүй болсон эсэх зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно./
- бодлого зохицуулалт, баталгаатай байх /энэ шалгуур нь ТУЗ, түүнтэй адилтгах удирдлагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үйл олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх,

терроризмтой тэмцэх чиглэлээр тавигдах шаардлага, ёс зүйн шалгуур зэргийг тусгасан бодлого, журамтай байх болон хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулагдах үйл ажиллагааг шударга, өөрийн болон бусад оролцогч талууд, үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн гүйцэтгэхийг илэрхийлсэн баталгаа гаргах зэрэг үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно./

- төрийн эрх бүхий байгууллагаас албадлагын эсхүл захиргааны шийтгэлгүй байх /энэ шалгуур нь Хорооны зохицуулалттай хуулийн этгээдийн хувьд өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авхуулсан эсэх болон Хорооны зохицуулалттай болон бусад хуулийн этгээдийн хувьд өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх үзүүлэлтээр тодорхойлогдоно./
- бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх /энэ шалгуур нь санхүүгийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол буруутай байсан эсэх,

сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх, Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх. Мөн Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно./

- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх / энэ шалгуур нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтад харшлаагүй байх, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан хуулиудтай харшлаагүй байх үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно./

Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд Хороо тухай бүр хяналт тавьж ажиллах бөгөөд тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаагүй, хангахгүй болсон тохиолдолд Хороо холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг авахаар журамд зохицуулагдсан.



ФИНТЕК БА РЕГТЕК

КОВИД–19 БА ФИНТЕК: БОДЛОГО ГАРГАГЧИД ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Ковид–19 цар тахлын халдвар, түүнийг дагасан эдийн засгийн хямрал, тодорхой бус байдлын нөлөөгөөр технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж буй олон тооны гарааны бизнесүүдэд санхүүжилт олох, үйл ажиллагаагаа жигд үргэлжлүүлэн явуулахад хүндрэл учирч буй хэдий ч өргөн утгаар нь авч үзвэл Ковид–19 цар тахал нь финтекийн салбарт томоохон боломжийг бий болгож байна.




Халдварт өвчлөл нь хүмүүс хоорондын харилцаа холбоо болон бизнесийн үйл ажиллагаанд нэлээдгүй том өөрчлөлтийг авчирж байгаа бөгөөд инноваци, технологийн дэвшил нь зайнаас харилцах,

ажиллах, бизнесийн үйл ажиллагаагаа зайнаас удирдах замаар таслалгүй явуулах, халдварт өвчлөлөөс сэргийлэхэд ихээхэн тусалж байгаа юм. Санхүүгийн харилцаанд биечлэн оролцох хэрэгцээг багасган, бэлэн мөнгөний хэрэглээг бууруулснаар финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эмзэг бүлэгт засгийн газрын тусламжийг хүргэх зэрэгт чухал хувь нэмэр оруулж байна.

Гэсэн хэдий ч улс орнуудын бодлого гаргагчид технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлэх болон санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах хоёр томоохон зорилтын дунд гацан хамгийн оновчтой зохицуулалтыг хайж олох гэж удаан хугацааг өнгөрөөж байна. Харин Ковид–19 цар тахал нь инноваци, технологийг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэх замаар зах зээлийн үр ашигт байдлыг сайжруулан санхүүгийн зах зээл, болон эдийн засгийн эмзэг байдлаас гарах тэнцвэрт арга замыг нэн даруй олох шаардлагатайг улс орнуудад сануулж байгаа юм.

Мэдээж энэхүү сорилтыг даван туулахад тохиромжтой цор ганц арга зам гэж байхгүй. Улс орон бүрийн санхүүгийн систем, эдийн засаг, зах зээлийн суурь хүчин зүйлээс шалтгаалан нэг улсад тохирсон зохицуулалтын арга хэрэгсэл, нөгөөд тохирохгүй байх нь олонтоо. Гэхдээ олон улсын байгууллагууд, судлаачид финтекийг зохицуулах 4 төрлийн хандлагыг тодорхойлоод байгаа бөгөөд бодлого гаргагчид эдгээр хандлагуудад суурилах замаар, өөрсдийн нөхцөлд тохирсон бодлогыг боловсруулах боломжтой юм.

Одоо финтек зохицуулалтын ямар хандлагууд зах зээлд байна вэ?



Эх сурвалж: Дэлхийн банк



✓ Хүлээх, ажиглах

Энэ нь санхүүгийн зах зээлд гарсан аливаа технологийн дэвшил, инновацийг зохицуулахаасаа өмнө ажиглах, тухайн инновацийн зах зээлд үзүүлж буй нөлөөг судлах, хянах зохицуулалтын хэлбэр юм. Дийлэнх улс орон финтекийн зах зээлд зохицуулалт хийхээсээ өмнө зах зээлд нэвтрээд буй инновацийг ойлгох, зохицуулагч байгууллагын чадавхыг сайжруулах зэрэг байдлаар уг хандлагыг баримталж байна.

✓ Турших, суралцах

Зах зээлд нэвтэрсэн инноваци тус бүрийг бодит зар зээлийн орчинд ажиллахыг нь зөвшөөрөн үйл ажиллагаанд нь хяналт тавих, тохирох бодлогын хэрэгслийг хайж олох арга хэлбэр.

✓ Инновацийг дэмжих

Инноваци, технологийг дэмжсэн зах зээлийн орчныг бүрдүүлэх зорилгоор төрөл бүрийн хэрэгсэл ашиглах. Үүнд:

1. Инновацийн хаб байгуулах. Технологийн дэвшлийг зах зээлд нэвтрүүлж буй инновацийн компаниудыг дэмжих, тэдэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, зохицуулалт, хяналттай орчинд үйл ажиллагаа явуулахад нь чиглэл өгөх, салбарын бусад оролцогчид болон академик судлаачидтай хамтран ажиллах боломжийг финтек компаниудад тус хаб нь олгодог. Жишээ нь Малайз, Тайланд, Сингапур зэрэг улсууд нь дижитал санхүүгийн үйлчилгээнд зориулсан технологийн хабыг байгуулсан.
2. Зохицуулалтын сэндрокс аргачлалыг нэвтрүүлэх. Орон зай, цаг хугацааны хязгаарлалттайгаар, зохицуулагч байгууллагын хараан дор бүтээгдэхүүн,

үйлчилгээ, бизнес загвараа бодит зах зээлд багасгасан хэмжээгээр туршиж үзэх боломжийг инновацийн компаниудад олгодог зохицуулалтын хэрэгсэл. Одоогийн байдлаар дэлхий даяар 80 гаруй сэндрокс хэрэгжиж байна гэж бүртгэгдсэн.

3. Зохицуулалтын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх. Энэ нь зөвхөн зах зээлд оролцогч финтек компаниуд технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлээд зогсохгүй санхүүгийн зохицуулагч байгууллага үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг нэвтрүүлэх буюу Рэгтекийг хөгжүүлэх замаар зах зээлийн оролцогчид, хэрэглэгчидтэй илүү үр дүнтэй харилцах механизм юм.

✓ Зохицуулалтын реформ хийх

Технологийн дэвшил нь зах зээлд цоо шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн байгууллагуудын бизнес загварыг өөрчилж байгаа учраас түүнд тохирсон шинэ хууль, дүрэм, журам боловсруулах, шинэ төрлийн тусгай зөвшөөрөл олгох, зохицуулалтын чадавхаа нэмэгдүүлэх зорилгоор реформ хийх зэрэг хэрэгцээ, шаардлага улс орнуудад тулгарч байна.

Бодлого гаргагчид хаанаас эхлэх хэрэгтэй вэ?

Бодлого гаргагчид эхлээд улс орныхоо нөхцөл байдлыг сайтар үнэлэн, зохицуулалтын байгууллагын эрх, хэмжээ, чадавхыг үнэлэх, бодлогын зорилтоо тодорхойлох, хууль, эрх зүй, зохицуулалтын орчиндоо шинжилгээ хийх, финтек салбар нь хөгжлийн ямар үе шатандаа явааг сайтар ойлгох шаардлагатай юм.

Дэлхийн банкны судалгааны үр дүнгээс харахад инновацийн хабыг зохицуулалтын сэндрокстой хамтад нь хэрэгжүүлэх нь илүү үр ашигтайгаас гадна, бизнесийн орчинд илүү ээлтэй байх хандлага ажиглагдаж байна. Инновацийн хабыг аль болох зардал багатайгаар, хурдан хугацаанд байгуулах нь зохицуулагч байгууллагуудад нүүрлээд буй хямралын үед зах зээлийн өөрчлөлтөд хурдан хариу үйлдэл үзүүлэхэд туслах боломжтой юм.

Технологийн дэвшил нь цоо шинэ зах зээлийн орчныг үүсгэж байгаа учраас түүнийг зохицуулах төгс тохирсон арга хэрэгсэл гэж байхгүй. Харин одоо байгаа арга хэрэгслийг дангаар нь эсхүл хосолмол байдлаар улс орон, зах зээл бүрийн онцлогт нийцүүлэн ашиглаж, хугацааны явцад улам илүү сайжруулан, шинэчилж явах нь чухал юм.

Халдварт өвчин гарсан энэхүү цаг хугацаа нь бодлого гаргагчдад финтекийн салбарт өөрчлөлт хийх, зохицуулалтын орчныг сайжруулах шаардлагатайг сануулан тус зах зээлд томоохон боломжийг бий болгож байна. Түүнчлэн санхүүгийн зах зээл хоорондын холбоо хамаарал улам бүр нэмэгдэн дэлхийн хэмжээний хямрал нүүрлэж буй өнөө үед улс орнуудын хамтын ажиллагаа, мэдлэг, туршлага солилцох сүлжээ, инновацийг дэмжих, нэгдсэн арга хэрэгсэл нь санхүүгийн зах зээл, эдийн засаг болон нийгэмд ихээхэн үр ашгийг үзүүлэх боломжтой юм.

Эх сурвалж:

Sharmista Appaya, Helen Luskin Gradstein, and Thervina Mathurin-Andrew. (May 12, 2020). "Fintech can help in the response to COVID-19. But where should policymakers start?". Retrieved from <https://blogs.worldbank.org/psd/fintech-can-help-response-covid-19-where-should-policymakers-start>

СУДЛААЧИЙН ИНДЭР

ВАЛЮТЫН ХАНШИНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Ч.Сосорбарам¹

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажил нь сүүлийн жилүүдэд ихээхэн хэлбэлзэмтгий байгаа валютын ханшинд нөлөөлж байгаа гадаад болон дотоод хүчин зүйлсийг тодорхойлох, гадаад хүчин зүйлсийн шокийн эрсдэлийг бууруулах арга замыг эрэлхийлсэн. Ийнхүү судалгааны үр дүнд манай валютын ханшийн 47 орчим хувийг гадаад хүчин зүйлс буюу түүхий эдийн үнэ нөлөөлдөг болох нь тогтоогдсон. Түүхий эдийн үнийг таамаглах нь манай орны валютын ханшийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах, валютын ханшийн хэт их өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авахад чухал ач холбогдолтой. Иймээс түүхий эдийн үнийг таамаглах одоогийн үнэ цэнийн хандлагыг авч үзсэн. Ийнхүү зэсийн дэлхийн үнийг дан ганц Чили улсын валютын ханшаар таамаглаж болохыг хүчтэйгээр нотолж харуулсан.

Түлхүүр үг : Гадаад дотоод хүчин зүйлс, түүхий эдэн валют, түүхий эдийн үнэ

I. ОРШИЛ

1.1 Судалгааны үндэслэл

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2013 онд 2 оронтой тоонд гарч, бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн өсөлтөөрөө тэргүүлсэн хэдий ч бодит нөхцөл байдалд макро эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилсээр байна. Уул уурхайн салбарт чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, гадаад худалдааны алдагдал 2,082.0 сая ам.долларт хүрсэн, оны сүүлийн хагаст зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт 2,083,310.4 сая төгрөгт хүртэл өссөн зэрэг нь ханшийн хэлбэлзлийг бий болгож, цаашид тодорхой бус байдлыг үүсгэж байна. 2013 оны 1 сарын байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1392 төгрөг байсан бол, 2014 оны 2 сарын байдлаар 1789 төгрөг болж 28%-р суларсан байна. Ханшийн өндөр хэлбэлзэл нь зах зээл дээрх үндсэн шийдвэр гаргагчдын хувьд тодорхой бус байдлыг үүсгэж, ханшийн эрсдэлийг бий болгож байна. Тиймээс зах зээл дээрх валютын ханшийн таамаглал хийж, ханшийн хугацаан цувааны бүтцийг шинжлэх, цаашлаад ханшид нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлсийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой болоод байна.

1.2 Судалгааны зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь валютын ханшинд нөлөөлөгч гадаад болон дотоод хүчин зүйлсийг бүтцийн загвар ашиглан тодорхойлох, гадаад хүчин зүйлсийн эрсдэлийг таамаглахад оршино.

Зорилт:

- Валютын ханшинд нөлөөлөгч гадаад болон дотоод макро хүчин зүйлсийг бүтцийн вектор авторегрессив загвар ашиглан тодорхойлох.
- Түүхий эдийн зах зээлд чухал нөлөө үзүүлдэг 5 улсын хувьд түүхий эдийн үнийн таамаглалыг дэвшүүлэх.

II. СУДЛАГДСАН БАЙДАЛ

Валютын ханшинд нөлөөлөгч гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлох хүрээнд:

Таамаглал хийх нэг хувьсагчийн загвар болон макро үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг VAR, SVAR загварын шокийн хариу үйлдэл, вариацийн задаргааг ашиглан тодорхойлсон судалгааны ажлууд. VAR болон SVAR загвар нь өөр өөрийн гэсэн онцлогтой. Тухайн судалгааны зорилгоос хамааран аль нэгийг нь ашиглаж болно. Монголын эдийн засгийг төлөөлөх SVAR загварыг Монгол банкны эдийн засагч Д.Ган-очир(2007) “Валютын ханшийн инфляцад үзүүлэх нөлөө: Бүтцийн вектор авто регрессив хандлага” ажилдаа хийсэн байдаг. Судалгааны гол зорилго нь Мөнгөний бодлогын сувгуудыг шалгахад оршиж байсан. Үүнд: i. Мөнгөний бодлогын хүү →M1 мөнгө →Инфляци ii. Мөнгөний бодлогын хүү →M1 мөнгө → Ханш →Инфляци. SVAR загварын үнэлгээнд зэсийн үнэ, A80 бензиний үнэ, төв банкны богино хугацаат үнэт цаасны хүү CBRR, M1 мөнгөний өөрчлөлт, ханш, инфляци гэсэн 7 хувьсагч оруулж үнэлсэн. үнэлгээний үр дүнд ам.доллартой харьцах төгрөгийн жилийн өөрчлөлтийн 1 хувийн өөрчлөлт 4–7 сарын хоцролттойгоор нөлөөлдөг бөгөөд ханшийн шок нь инфляцийн хэлбэлзлийн 13,3–16,3 хувийг тайлбарлаж байсан...

Валютын ханшаар түүхий эдийн үнийг таамаглах нь хүрээнд:

Yu–Chin Chen, Kenneth S.Rogoff, Barbara Rossi нарын 2013 онд хийсэн “Can exchange rates forecast commodity prices ? ” гэсэн судалгааны ажилдаа цөөн тооны бүтээгдэхүүн экспортолдог орны валютын ханш нь дэлхийн бүтээгдэхүүний үнийг баттайгаар таамаглаж байна уу гэдгийг харуулахыг зорьсон. Ийнхүү таамаглал хийх нь тухайн экспортлогч орны урсгал данс хаашаа хөдлөх вэ гэсэн динамикийг гаргаж ирэх боломжтой болгосон. Экспортын орлого нь эдийн засагт экспортын орлогоор дамжин нөлөөлөх, оруулалтын сувгаар дамжин нөлөөлөх боломжтойг харуулж өгсөн. Ингэхдээ түүврийн дотор болон гаднах харилцаа холбоог авч үзсэн. Барааны үнэ нь валютын ханшийг тодорхойлж байна уу, эсвэл валютын ханш нь бүтээгдэхүүний үнийг тодорхойлж байна уу гэдгийг Гранжерийн учир шалтгааны тест ашиглан хийсэн. Дээрх судалгаандаа Австрали, Канад, Чили, Шинэ–Зиланд, Өмнөд Африк зэрэг хөдөө аж ахуйн болон уул уурхайн анхдагч бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орнуудын валютын ханш болон экспортын бүтээгдэхүүнийг хамруулсан улирлын тоон мэдээллийг ашигласан. Судалгааны үр дүнд валютын ханш болон экспортын бүтээгдэхүүний хооронд хүчтэй харилцан хамаарал байгаад зогсохгүй валютын ханшаар дамжуулан ирээдүйн экспортын үнийг таамаглаж болдог гэсэн үр дүнд хүргэсэн. Судалгааны төгсгөлд түүхий эдэн валют буюу экспортын 50–с дээш хувийг нүүрс, алт, зэс эзэлдэг жижиг орнуудын хувьд дээрх судалгааг хийх нь сонирхолтой байж болох талаар дурдсан байдаг...

¹ Санхүүгийн зохицуулах хороо, ҮХХЗҮЭЗГ-ын мэргэжилтэн, эдийн засагч Email: sosorbaram@frc.mn

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлнэ. Тус судалгаатай холбоотой аливаа санал, зөвлөмж, шүүмжийг хүлээн авахдаа таатай байх болно.

III. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Судалгааны хэрэглээ, ач холбогдол

Манай орны хувьд сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалт, түүхий эдийн үйлдвэрлэл нэмэгдсэн нь валютын ханшийг ихээхэн хэлбэлзэмтгий болгож байна. Тиймээс ААН, иргэдийн хувьд валютын ханшийг таамаглах, түүнд нөлөөлж байгаа голлох макро үзүүлэлтүүдийг илрүүлэх нь ач холбогдол өндөртэй байна.

IV ОНОЛЫН ХЭСЭГ.

4.1 Вектор авторегрессив загвар²

Вектор авторегрессив загварыг ерөнхий хэлбэрт бичвэл:

К хэмжээт Y_t , $t=1,2,3 \dots T$ хугацаан цувааг авч үзье. Y_t -ыг хугацаан төгсгөлөг р хоцролтой гэе. Онолын хэсэгт хийх бидний гол зорилго бол VAR загварын параметруудийг судлах юм. Загварын хувьсагчдыг вектор хэлбэрээр бичвэл:

$$B_0 Y_t = B_1 Y_{t-1} + \dots + B_p Y_{t-p} + u_t$$

Энд: u_t - серийн корреляци байхгүй тэг дундажтай вектор байна. Үүнийг бүтцийн шок гэж нэрлэнэ. Энэ нь нөгөө талаараа нөхцөлт бус хомоскедасити юм.

Загварыг ялгаварт оператор ашиглан бичвэл: $B(L) Y_t = u_t$

Энд: $B(L)$ нь р дүгээр эрэмбийн хугацаан хоцролттой функц буюу $B(L)=B_0 - B_1 L - B_2 L^2 - \dots - B_p L^p$ байна. Энд B_0 матриц нь диагоналийн элементүүд нь 1 байхаар нормчлогдсон нэгж бус матриц юм. Бүтцийн алдааны вариаци ко-вариацийн матрицыг: $E(uu') = \sum u = I_k$ Вариаци ко-вариацийн матриц нь к хэмжээт гэдгээс загварт байгаа хувьсагчийн тоотой тэнцүү бүтцийн алдаа байна мөн I_k диагональ гэдгээс шокууд хоорондоо ижил цаг хугацааны хамааралгүй. Бүтцийн загварыг үнэлэхийн тулд хураангуй хэлбэрийг гаргаж авах хэрэгтэй. Y_t -ийг $Y_{t-1}, Y_{t-2} \dots Y_{t-p}$ хоцролтоор илэрхийлсэн функц болгохын тулд тэгшитгэлийн хоёр талыг B_0^{-1} -ээр үржүүлнэ.

$$B_0^{-1} B_0 Y_t = B_0^{-1} B_1 Y_{t-1} + \dots + B_0^{-1} B_p Y_{t-p} + B_0^{-1} u_t$$

Дээрх загварыг дахин бичвэл:

$$Y_t = A_1 Y_{t-1} + \dots + A_p Y_{t-p} + e_t, A(L) Y_t = e_t$$

Хураангуй хэлбэр нь бүтцийн параметруудийг тууштай үнэлэхэд тус болно. Энд B_0 матрицид богино хугацааны хязгаарлалт тавигдсан байгаа. $e_t = B_0^{-1} u_t$ гэдгээс хязгаарлалтуудын параметруудийг гаргаж авна. Загвар өөрөө яг тодорхойлогдсон давтагдагч систем учир ЭХБК аргаар үнэлж болно.

4.2 Одоогийн үнэ цэнийн хандлага

Энэ хандлага нь одоогийн үнэ цэнийн утга нь нэрлэсэн валютын ханш болон ирээдүйд хүлээгдэж байгаа суурь хувьсагчийн нормчлогдсон нийлбэрийн хоорондох хамаарлыг харуулдаг.

$$s_t = \gamma \sum_{j=0}^{\infty} \psi^j E_t(f_{t+j}|I_t) \quad (1)$$

Y болон ψ^j нь параметрууд бөгөөд онцгой бүтцийг загварыг илэрхийлнэ. E_t нь хүлээлтийн оператор бөгөөд I_t гэсэн мэдээллийн түвшинд. Энэ нь одоогийн үнэ цэнийн тэгшитгэлээр дамжуулан валютын ханш s -ийг суурь f -тэй Гранжер учир шалтгаан(ГУШ) шалгах хэрэгтэй гэж үзүүлэх юм. Түүхий эдийн үнэ нь эдгээр улсуудын валютын ханшинд суурь үзүүлэлт болдог ороо учир шалтгаан нь тодорхой, одоогийн үнэ цэний онолын хандлага нь учир утгатай байгаа юм. Хэрэв түүхий эдийн үнэ ирээдүйн валютын ханшийг таамаглахгүй гэвэл 1-р тэгшитгэл нь валютын ханш дэлхийн зах зээлийн үнийг таамагладаг гэдгийг харуулдаг. Ийм учраас түүхий

эдийн үнийг тухай зах зээлийн мэдээлэл тулгуурлан таамаглаж болно гээд тэгшитгэл нэгээс $\Delta c p_t = f_t$ гэвэл

$$s_t = \gamma \sum_{j=0}^{\infty} \psi^j \Delta c p_{t+j} + z_{t+1} \quad (2)$$

z нь түүхий эдийн үнийн үнээс үл хамаарах бусад валютаар тодорхойлогдсон хэсэг.

$\Delta c p$ гэдэг нь Δs_{t+1} -ийг таамаглахад эконометрикийн хувьд ашиглагдахгүй. Гэвч Δs_t нь $\Delta c p_{t+1}$ таамаглахад ашигладаг. Учир нь энэ нь X_{t+1} тухай мэдээллийг агуулдаг. $\Delta c p_t = X_t$

V. ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Шинжилгээний эхний хэсэгт ам.долларын ханшийг нефтийн үнэ, зэсийн үнэ, ам.доллараар хадгаламжийн хүүний зөрүү, ДНБ-ийн зөрүү, м1 мөнгөний нийлүүлэлт, ам.доллар, инфляци гэсэн 7 хувьсагчтай SVAR загвар үнэлж хэлбэлзэл бий болгогч гол макро үзүүлэлтийг илрүүлнэ. Дараа нь түүхий эдийн үнийг шууд нөлөө үзүүлэгч 5 улсын валютын ханшаар таамаглана.

5.1.1 Ам.долларын ханшинд нөлөөлөгч гадаад, дотоод хувьсагчийг тодорхойлох

Бүтцийн вектор авторегрессив загварт оруулсан макро үзүүлэлтүүд: Нийт 6 хувьсагч авч үзсэн.

Газрын тосны дундаж үнэ: Газрын тосны үнэ өсөх нь тээврийн зардал, үйлдвэрлэлийн зардлыг өсгөдөг. Мөн шаардагдах газрын тосыг авахын тулд гадаад валютын эрэлт өснө гэж таамаглаж болох юм. Гадаад валютын эрэлт өсөх нь дотоод валютын ханшийг сулруулж болох юм. Гадаад хувьсагч гэж авч үзнэ.

Зэсийн үнэ: загварт эрэлтийн талын шокийг төлөөлүүлж оруулж байна. Зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр өсөх нь Монголоос зэс импортлодог орнуудын хувьд төгрөгийн илүү их эрэлтийг бий болгох боломжтой. Дотоод валютын эрэлт өсөх нь дотоод валютыг чангаруулж болно. Гадаад хувьсагч гэж авч үзнэ.

Хадгаламжийн хүүний зөрүү: Эдийн засгийн онолын хувьд хүүгийн пратет хангагддаг гэж үзвэл. Дотоодын хадгаламжийн хүү өндөр байх нь дотоод валютын эрэлтийг өсгөдөг. Энэ эрэлтийн өсөлт нь дотоод валютыг чангаруулж болно.

Гадаад валютын албан нөөц: Төв банк интервенц хийх замаар гадаад валютын зах зээлд оролцдог.

M1- мөнгөний өөрчлөлт: эдийн засаг дахь M2 мөнгө нэмэгдэх нь дотоод валютыг сулруулдаг. Тиймээс валютын ханшинд нөлөөлтэй байж болох юм.

Валютын ханш: Валютын ханшны хэлбэлзлийг бий болгож байгаа шалтгааныг тодорхойлох гэж байгаа тул ханшийн цувааг оруулж байна.

5.1.2 Бүтцийн вектор авто регрессив загвар

- [1] $nept_t = E_{t-1} nept_t + e_t^{nept}$
- [2] $cop_t = E_{t-1} cop_t + e_t^{cop}$
- [3] $dr_t = E_{t-1} dr_t + e_t^{dr}$
- [4] $res_t = E_{t-1} res_t + e_t^{nept} + e_t^{cop} + e_t^{dr} + e_t^{res}$
- [5] $m1_t = E_{t-1} m1_t + e_t^{nept} + e_t^{cop} + e_t^{dr} + e_t^{res} + e_t^{m1}$
- [6] $usd_t = E_{t-1} usd_t + e_t^{nept} + e_t^{cop} + e_t^{dr} + e_t^{res} + e_t^{m1} + e_t^{usd}$

SVAR загварын үнэлгээнд оруулж байгаа бүх хувьсагчид нэг язгуургүй болсон болно(хавсралт). Үнэлгээнд нийт 132 сарын тоон мэдээлэл үнэлэгдсэн.

2 Luts and Kilian (2011) "Structural Vector Autoregressions"

5.1.3 Ханшийн SVAR үнэлгээ, эмпирик үр дүнгүүд

Валютын ханшинд нөлөөлөгч гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлох вектор авторессив загварын үнэлгээний үр дүнг хүснэгт.-д үзүүлэв. Хүснэгтээс харвал зэс, нефтийн үнэ, M1 мөнгөний нийлүүлэлтэд гарсан шок манай улсын ам.доллартай харьцах төгрөгийн ханшинд нөлөөтэй болохыг статистикийн хувьд хүлээн зөвшөөрч байна.

Хүснэгт 1 Вектор авторегрессив загварын үнэлгээ

	NEPT	COP	DR	RES	M1	USD
B_0	1	0	0	0	0	0
	0	1	0	0	0	0
	0	0	1	0	0	0
	-79,11038 (0,0565)*	-8,150748 (0,817)	-0,73281 (0,4596)			
	0,015915 (0,7697)	-0,030419 (0,5048)	0,000279 (0,8281)	-0,000246 (0,0238)**	1	0
	0,046965 (0,0306)**	0,041221 (0,0239)**	-0,00047 (0,36)	0,0000131 (0,7666)	0,045044 (0,179)	1


***, **, * - нь харгалзан 1%, 5%, 10%-ын түвшинд тус хувьсагч ач холбогдолтой буюу нөлөөтэй гэдгийг илтгэнэ.

Загварт нефтийн бүтээгдэхүүнийг оруулахдаа нефтийн үнэ өсөх нь валютын ханшийг сулруулна гэсэн таамаглал тавьж оруулсан. Үнэлгээний хувьд таамаглалыг баталж байна нефтийн үнийн нэг хувийн эерэг шок төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг 0,04 функтээр сулруудаг байна. M1 мөнгөний хувьд таамаглалтай нийцтэй байна. Зах зээл дээрх m1 мөнгөний нийлүүлэлтийг 1 хувиар нэмэгдүүлэхэд төгрөгийн ханшыг 0,04 функтээр сулруулдаг гэсэн үр дүн өгч байна. Хадгаламжийн хүүний зөрүү статистикийн хувьд ач холбогдол байхгүй боловч төгрөгийн ханштай сөрөг хамааралтай байна. Гадаад валютын нөөцийн өөрчлөлтөд нефтийн үнэ сөрөг нөлөөтэй байна. Нефтийн үнэ өсөх нь гадаад валютын нөөцийг бууруулахаар байна. Үйлдвэрлэл, үйлчилгээнд нефт зайлшгүй шаардлага байдаг тул үнэ өссөн хэдийч нефтийг авах тул гадаад валютын нөөцийг бууруулж байж болох юм.


5.1.4 Валютын ханшинд нөлөөлөгч хүчин зүйлсийн сувгийг шалгах нь:

Энэ хэсэгт статистикийн хувьд ач холбогдолтой гарсан хувьсагчдын нэг нэгжийн стандарт хазайлтад валютын ханшийн үзүүлэх хариу үйлдлийг танилцуулна. Газрын тосны үнэд гарсан нэг нэгж шок валютын ханшинд 3 сарын дараа хамгийн дээд цэгтээ хүрдэг байна. 5 дахь сараас статистикийн хувьд ач холбогдолгүй арилж байна.

Зураг 1 Нефть, хүүний зөрүүний шокийн нөлөө



Хадгаламжийн хүүний зөрүүний шокийн нөлөө




Хадгаламжийн хүүний зөрүү нэмэгдэх нь төгрөгийн ханшийг сулруулдаг бөгөөд 2 сарын дараа огцом цочрол өгдөг бөгөөд дараагийн саруудаас шокийн нөлөө аажмаар арилж байна.

5.1.5 Вариацийн задаргаа

Валютын ханшийн хэлбэлзлийн бусад хувьсагч болон өөрийнхөө цуваанаас хэрхэн хамаарч байгаа вариацийн задаргаагаар тайлбарладаг. Загварт нефтийн үнэ, зэсийн үнийг гадаад хувьсагчид хэмээн авч үзсэн. Гадаад, дотоод хувьсагчид валютын ханшны хэлбэлзлийн 47 орчим хувийг тайлбарлаж байна. Харин хадгаламжийн хүүний зөрүү, M1 мөнгө, Валютын цэвэр албан нөөцийн өөрчлөлт зэрэг үзүүлэлт нийтдээ 5 орчим хувийг, үлдсэн 48 хувийг валютын ханшийн цуваа өөрөө үүсгэж байна.

Зураг 2 Ханшийн вариацийн задаргааны хувь




Эндээс үзвэл валютын ханшинд нөлөөлөгч өөр бусад шокууд 48 хувь дотор багтаж байгаа юм. Загвар оруулсан хувьсагчдын хувьд 47 хувь нь гадаад хувьсагчаас, 5 хувь нь дотоод хувьсагчаас үүдэлтэй байна. Үлдсэн 47 хувийг шууд дотоод, гадаад гэж тайлбар өгөх нь үндэслэлгүй байна. Дээрхээс харвал Монголын төгрөгийн ханш дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнээс шууд хамааралтай байгааг харж болно.

5.2.1 Түүхий эдийн үнийг таамаглах нь

Доорх тэгшитгэлээр дэлхийн түүхий эдийн үнийг таамагласан.

$$E_t \Delta c p_{t+1}^w = \beta_0 + \beta_{11} \Delta s_t^{AUS} + \beta_{12} \Delta s_t^{CAN} + \beta_{13} \Delta s_t^{CIP} + \beta_{14} \Delta c p_{t-1}^w + \beta_{15} \Delta c p_{t-2}^w$$

Зураг 3 Түүхий эдэн валютаар түүхий эдийн үнийг таамаглах нь



Дээрхээс харахад хэд хэдэн валютын ханш нь дэлхийн түүхий эдийн үнийн өөрчлөлтийг түүврийн дотор болон гадна маш сайн таамагладаг. Ингээд бид шинжилгээг илүү үр дүнтэй болгохын тул валютын ханшийн тэгшитгэлээ үнэлсэн.

Хүснэгт 2 Bivariate Granger Causality test

	AUS	CAN	CHI	MON	SA
Талбар А p-value $H_0: \beta_0 = \beta_1 = 0$	$\Delta cpr_{t+1} = \beta_0 + \beta_1 \Delta s_t + \beta_2 \Delta cpr_t$				
	0.0008***	0.0000***	0.0000***	0.0418**	0.0000**
Талбар Б p-value $H_0: \beta_0 = \beta_1 = 0$	$\Delta s_{t+1} = \beta_0 + \beta_1 \Delta cpr_t + \beta_2 \Delta s_t$				
	0.0000***	0.0000***	0.0000***	0.1209	0.0002***

1% (***), 5% (**), 10% (*) тус тус ач холбогдлын зэргийг илэрхийлэх бөгөөд дээрх ач холбогдлын түвшинд Гранжер учир шалтаан байна гэдгийг нотолж байгаа юм.

Хүснэгтээс харахад Монголын валютын ханшинд түүхий эдийн үнэ учир шалтгаангүй гэснээс бусад нь таамаглалын хувьд хүлээн зөвшөөрөгдөж байна. Хүснэгт 2-ын ажлын талбар дээр УШТ (Учир Шалтгааны Тест гэж) –д суурилсан таван валютын ханш, тэдгээрийн ижил төсөөтэй түүхий эдийн индексийг харуулж байна. УШ тестийн хамгийн дутагдалтай тал нь цуваан дах тогтворгүй параметруудийг авч үздэггүй. Хүснэгт 2-³ хувьсагчдын тогтвортой байдлыг харуулах олон хугарлын цэгийн Bai-Peron тест хийсэн. Энэ нь бусад төрлийн хугарлын цэгийг шалгах тестээс олон талаараа давуу талтай байдаг. Манай орны хувьд хүснэгт 2-ын талбар А дээрх үр дүнгээс харахад 2004 оны 2-р сар, 2009 оны 2-р сар, 2011 оны 6-р сард тус тус хугарал гарсан. Харин талбар Б-ийн үр дүнгээс харахад 2006 оны 11-р сар, 2009 оны 3-р сар, 2011 оны 9-р сард тус тус бүтцийн өөрчлөлт орсон байна гэдгийг үзүүлж байна. Эндээс харахад сүүлийн жилүүдэд манай орны валютын ханш болон түүхий эдийн үнэд бүтцийн өөрчлөлт ойр ойрхон өөрчлөлт орж байж болзошгүйг харуулж байна.

5.2.2 Валютын ханшаар дэлхийн нийт түүхий эдийн үнийн өөрчлөлтийг таамаглах нь?

Валютын ханшаар улсуудын түүхий эдийн экспортын сагсыг үнийн өөрчлөлтийг таамаглаж болно. Дараа нь бид бүхий л түүхий эдийн валютын мэдээллийг нэгтгэн дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх үнийн мөчлөгийг таамаглаж болно. Дэлхийн зах зээлийн индекс, бид өмнө нь тодорхойлж байсан IMF(CP)-с түүхий эдийн нийт үнийг таамаглахад ашигласан. Үнэндээ бол дэлхийн түүхий эдийн үнэ голчлон дэлхийн шокоос, тэгэхэд түүхий эдэн валют болон валютын ханш тухайн орны шокоос хамаардаг гэж хүлээдэг. Эхлээд дэлхийн үнийн индексийг түүвэр дотор таамагласан, урт хугацааны валютын ханшийн цуваа бүхий орнуудыг ашиглан УШР-ийг олон хувьсагч дээр хийсэн.

$$E_t \Delta cpr_{t+1}^w = \beta_0 + \beta_{11} \Delta s_t^{aus} + \beta_{12} \Delta s_t^{can} + \beta_{13} \Delta s_t^{chile} + \beta_2 \Delta cpr_t^w \quad (5)$$


Түүврийн гаднах таамаглалыг хийхдээ олон хувьсагчаар таамаглах, нэг хувьсагчдын нэгдлээр таамаглах гэсэн 2 хандлагыг авч үзсэн. Олон хувьсагчийг таамаглахдаа ижил төрлийн 3 валютын ханшийг тэгшитгэл 5-д харуулсан шиг үнэлж өмнөх хэсэгт дурдаж байсан адил өнхрөгч регрессийн үйл явцаар таамагладаг. Бид дахин Clark and McCracken's нарын ENCNEW тестийг ашиглан 3 суурь загварын таамаглалтай загварын таамаглалыг харьцуулан үнэлсэн. Дэлхийн түүхий эдийн үнийн индексийн өөрчлөлтийг харуулсан жинхэнэ

таамаглалд суурилсан валютын ханшийг зурах үед энэ таамаглалын хүч нилээд илэрхий болж ирдэг. Эхлээд бид 3-н регресс үнэлнэ, дэлхийн түүхийн эдийн үнийн таамаглалыг нэг шатат процессоор үнэлнэ. /one-step-ahead/

$$E_t \Delta cpr_{t+1}^{w,i} = \beta_{0,i} + \beta_{1,i} \Delta s_t^i \quad (6) \text{ энд } i = \text{AUS, CAN, CHI, MGL}$$

Ийнхүү 6 гэсэн тэгшитгэлийг өөрийн цуглуулсан орон бүрт шалгаж үзсэн бөгөөд ингэхэд Чилийн валютын ханш буюу Доллараар илэрхийлсэн Песо нь дэлхийн зэсийн үнийг дангаараа таамаглаж чаддаг гэдгийг түүврийн цонх нь нийт түүврийн хэмжээний хагастай тэнцэх хэмжээний цонхоор гүйлгэн өнхрөгч регресс үнэлэн гаргаж ирсэн Зураг 4-т харуулж байгаагаар чилийн мөнгөн тэмдэгт дэлхийн зэсийн үнийг таамаглах боломжтой нь харагдаж байна.

Зураг 4. Дэлхийн зэсийн үнийг дан Чилийн валютын ханш таамаглаж байгаа нь



VII. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Манай орны хувьд валютын ханшны зах зээл нь уул уурхайн салбараас хэт хамааралтай учраас хэлбэлзэл өндөртэй байна. Ханшийн өндөр хэлбэлзэл нь зах зээл дээрх үндсэн шийдвэр гаргагчдын хувьд тодорхой бус байдлыг үүсгэж, ханшийн эрсдэлийг бий болгож байна. Гадаад хүчин зүйлсийг тодорхойлсноор гадаад хүчин зүйлийн эрсдэлийг хэрхэн бууруулах боломжтой вэ гэдэг нэг арга замыг харуулсан.

Олон хувьсагчийн үнэлгээний үр дүн

- Загварт нефтийн бүтээгдэхүүнийг оруулахдаа нефтийн үнэ өсөх нь импортын бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж, улмаар зах зээл дээр инфляцыг бий болгоно. Эргээд энэ нь төгрөгийн ханшийг сулруулна гэсэн таамаглал тавьж оруулсан. Үнэлгээний хувьд таамаглалыг баталж байна нефтийн үнийн эерэг шок төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг сулруулдаг байна.
- M1 мөнгөний хувьд онолын таамаглалтай нийцтэй байна. Зах зээл дээрх M1 мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд зах зээл дээрх мөнгөний хэмжээ өсөж, энэ нь төгрөгийн ханшийг сулруулдаг гэсэн үр дүн өгч байна.
- Хадгаламжийн хүүний зөрүү статистикийн хувьд ач холбогдол байхгүй боловч төгрөгийн ханштай сөрөг хамааралтай байна.
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл дэх гадаад хувьсагчдын нөлөө 47 хувь буюу маш өндөр жин эзэлж байна. Энэ нь гадаад зах зээл дээр нефт, түүхий эдийн үнэ хэлбэлзэхэд манай ханш дагаж хэлбэлзэнэ гэдгийг хэлж байна. Нэгэнт тухайн эдийн засаг нь уул уурхайгаас өндөр хамааралтай улс болсон учир гадаад эдийн засгийн нөлөөлөл өндөр байна.

3 Bai-Peron тестийн дэлгэрэнгүй хавсралт хэсгээс улс бүр дээр тооцсон үр дүнг харна уу.

Валютын ханшаар түүхий эдийн үнийг таамагласан шинжилгээний үр дүн

- Энэ судалгааны ажлаар орлогын нөлөө болон худалдааны нөхцөлөөр дамжсан түүхий эдийн үнэ болон валютын ханшийн хоорондох уялдааны бүтцийг судалж, түүхий эдийн үнийн өөрчлөлт болон валютын ханшийн мөчлөгийн хоорондох динамик холбоог эмпирик байдлаар илрүүлсэн. Валютын ханш түүхий эдийн ирээдүйн үнийг таамаглахад ашиглагддаг гэдгийг харуулсан. Ялангуяа стандарт суурь үзүүлэлтүүд эндоген, орхигдуулсан хувьсагчид нь параметруудийн тогтворгүй байдлыг бий болгож хугацаан цувааг богино болгодог, валютын ханшийн тэгшитгэлийг шалгахад нарийн төвөгтэй болгосон.
- Chen and Rogoff нарын ажлын үр дүнтэй ижил үр дүнд хүрсэн ба жижиг улсуудад ч гэсэн валютын ханш нь тухайн орны экспортын бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийг тааварлах боломжтой гэдгийг харууллаа.

Ашигласан эх сурвалж*Монгол хэл дээрх эх сурвалжууд*

1. Б.Номун, Г.Цэнд-Аюуш, Б.Энхтуяа, “Зэсийн үнээр хөтлүүлсэн ам долларын ханшийн таамаглал”, (2013)
2. Ж.Пүрэвсүрэн, Э.Батмандахь “Валютын ханшийн богино хугацааны таамаглал хийх нь”, (2012)

3. Б.Эрдэнэбат “Макро эдийн засгий эрсдлүүд” судалгааны ажил 2012 7 сар

Англи хэл дээрх эх сурвалж

1. Jeffrey M Wooldridge, “Introductory Econometrics”, (2009), 4th edition
 2. David H. Papell “Exchange rate and Current account Dynamics under Rational Expectation : Econometric analysis”, (1986), International Economic Review. Vol. 27, No 3
 3. Giovanni Piersanti, “Expected future Budget Deficit, the Real Exchange rate and Current account dynamics finite Horizon Model”, (2002), Journal of Economics Vol. 77, No 1
 4. Yu-Chin Chen, Kenneth S. Rogoff, Barbara Rossi, (2010), Quarterly journal of economics
 5. Massimo Giuliadori, “Nominal shocks and The Current account a structural Var analysis of 14 OECD countries” (2004), review of world economics, Weltwirtschaftliches Archiv, Vol 140
 6. Babatunde W. Adeoye, Akinwande A. Atanda (2008). “Exchange rate Volatility in Nigeria: Consistency, Persistence and Severity Analyses”. <http://www.jstor.org/>
 7. Aurea Grane, Helena Viegas (2009). “Wavelet-based detection of outliers in Volatility models” <http://econpapers.repec.org/paper/ctewsrepe/ws090403.htm>
- Luts and Killian “Structural vector auto



ТАНИЛЦУУЛГА

“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТББ



**CORPORATE
GOVERNANCE
DEVELOPMENT
CENTER**

Corporate Governance Development Center буюу Компанийн Засаглалын Хөгжлийн Төв (КЗХТ) нь Санхүүгийн Зохицуулах

Хороо (СЗХ) болон Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн хамтын санаачилгаар 2009 онд үүсгэн байгуулагдсан.

Тус байгууллага нь салбартаа анхдагч мөн тэргүүлэгч мэргэжлийн байгууллага бөгөөд Монголын компаниудын засаглалыг сайжруулах зорилгоор 2009 оноос мэргэжлийн сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээ болон компанийн засаглалын мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, хууль эрх зүй, бодлого боловсруулалтын хүрээнд нөлөөлөл үзүүлэх ажлуудыг тасралтгүй хийж, Олон Улсын Санхүүгийн Корпораци, СЗХ, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар, Монголын Хөрөнгийн Биржтэй хамтран бизнесийн эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж ирсэн юм.



КЗХТ нь компанийн засаглалын олон улсын стандарт дээр тулгуурласан, Монголын эрх зүй, бизнесийн орчныг тусгасан компанийн засаглалын цогц сургалтыг явуулдаг бөгөөд 2009 оноос хойш КЗХТ-өөс нийтдээ 138

удаагийн мэргэжлийн сургалт явагдаж, ТУЗ-ийн гишүүд, захирлууд анхан шатны болон ахисан шатны засаглалын сургалтуудад хамрагдсан байна. Мөн компанийн засаглалаар мэргэшүүлэх зорилго бүхий магистрын нэг жилийн хөтөлбөрийг Санхүү Эдийн Засгийн Их Сургуультай хамтран 2015 оноос хойш амжилттай хэрэгжүүлсэн юм.



Үйл ажиллагааны хувьд орчин үеийн компанийн засаглалын тогтолцоог бий болгохын төлөө, мөн олон улсын санхүүгийн зах зээл дээр өрсөлдөхөөр зорьж буй компаниудад мэргэжлийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг төдийгүй компанийн засаглалын чиглэлийн судалгаа, шинжилгээг академик түвшинд болон хэрэглээнд зориулсан байдлаар хийдэг.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

2009 оноос эхлэн СЗХ-той хамтран компанийн засаглалын форум, компанийн засаглалын бүхий л төрлийн сургалт, судалгаа, төсөл хөтөлбөр, компанийн засаглалын үнэлгээ хийх гэх мэт үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллаж ирсэн юм. Тухайлбал:

- 2011 онд Компанийн Засаглалын Үндэсний хөтөлбөр

боловсруулах ажлын хэсэгт орж, Үндэсний хөгжил, Шинэтгэлийн хороо, СЗХ-той хамтран хөтөлбөрийн төсөл боловсруулсан;

- 2011 онд Олон Улсын Санхүүгийн Корпораци, СЗХ, КЗХТ хамтран “Компанийн шинэчлэн батлагдсан хууль ба компанийн засаглал” бага хурлыг зохион байгуулсан;
- КЗХТ, Олон Улсын Санхүүгийн Корпораци, СЗХ, Монголын Хөрөнгийн Биржтэй хамтран “Монголын компанийн засаглал: Боломжууд ба тулгарч буй бэрхшээлүүд” сэдэвт хэлэлцүүлэг семинарыг 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан;
- Олон Улсын Санхүүгийн Корпораци, СЗХ, КЗХТ хамтран Монголын Хөрөнгийн Биржийн Топ 20 компанийн засаглалын үнэлгээний тайлангийн хэвлэлийн бага хурлыг 2013 оны 11 дүгээр сарын 21-нд зохион байгуулсан;
- Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниуд, төрийн өмчит компаниудын тайлагналын тогтолцоог олон улсын жишигт хүргэж хөгжүүлэх зорилго бүхий уг төслийг 2015 онд КЗХТ болон СЗХ, Төрийн Өмчийн Хороо, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран нэг жилийн туршид хэрэгжүүлсэн бөгөөд энэ хугацаанд оролцогч компаниудын удирдлагуудыг сургах, хэлэлцүүлэг хийх, тайлан бичихэд нь зөвлөх, хараат бус шүүгчдийн зөвлөлийг байгуулан тайлангуудыг уралдуулах, шилдэг тайланг шалгаруулах арга хэмжээнүүд зохион байгуулсан;
- Төсөлд нийт 20 төрийн өмчийн болон хувьцаат компаниуд оролцон олон улсын сайн туршлагын дагуу 2015 оны тайлангаа гаргасан бөгөөд “АПУ” ХК-ийн тайлан “2015 оны шилдэг жилийн тайлан” уралдааны цомыг гардан авсан;
- Компанийн засаглалын ахисан түвшний сургалтыг СЗХ, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар болон КЗХТ хамтран 2020 оны 7 дугаар сарын 03-ны өдөр СЗХ-ны удирдах ажилтнуудад зохион байгуулсан.

БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

КЗХТ нь Олон Улсын Санхүүгийн Корпораци болон СЗХ-той хамтран 2011 оноос компанийн засаглалын форумыг жил бүр амжилттай зохион байгуулж ирсэн юм. Тухайлбал:

- 2011 он** Компанийн засаглал – Хөрөнгийн зах зээл
- 2012 он** Хувийн компанийн засаглал
- 2013 он** Санхүүгийн байгууллагын засаглал
- 2014 он** Зохицуулалттай байгууллагын засаглал
- 2015 он** Тайлагнал ба ил тод байдал
- 2016 он** Монголын компанийн засаглалын үр нөлөө: Төр, иргэний нийгмийн байгууллагууд, компаниудын үүрэг


2018 он Тогтвортой компаниудыг бий болгоход хөрөнгө оруулагчид болон зохицуулагч байгууллагуудад тулгарч буй сорилт гэсэн сэдвүүдээр Монголын компанийн засаглалын форумыг жил дараалан зохион байгуулж, бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгч болон зохицуулагч байгууллагууд, олон улсын зөвлөх байгууллагууд, үндэсний компаниуд, судалгаа сургалтын байгууллагуудын төлөөллүүдийг хуран цуглуулж, сэдэв бүрээр хэлэлцүүлж ирсэн. Форум өргөн цар хүрээнд болж 100–200 төлөөлөл нэг дор цуглан, тухайн жилийн сэдвийн хүрээнд санал бодлоо солилцох, шийдэл санал болгох зэргээр бодлогын нөлөөлөл үзүүлж ирсэн юм.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ РАДИОТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо Монголын үндэсний радиотой хамтран долоо хоног тутам иргэдийн санхүүгийн боловсролд зориулж радио нэвтрүүлэг хүргэж байгаа билээ. Радиогийн нэвтрүүлэгт “Амьдралын даатгалын ач холбогдол”, “Даатгалын зуучлал” болон

“Орон сууцны даатгал” сэдвээр “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Монголхүү, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн даатгал хариуцсан захирал А.Мөнхбазар, “Цахим капитал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Билгүүн нар оролцлоо.



МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ЭЭЛЖИТ СУРГАЛТ БОЛЛОО

СЗХ-ны 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 245 дугаар тогтоолын хавсралт “ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага”-ын 2.1 дүгээр зүйлийн 2.1.12-т заасан “ХЗХ-ны ТЗ, ХЗ, гүйцэтгэх захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын Үндэсний Холбооны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан байх” гэсэн шаардлагын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо нь Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоотой

хамтран “Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа” сургалтыг 2020 оны 8 дугаар сарын 13-наас 14-ний өдрүүдэд зохион байгуулсан ба сургалтад 8 хадгаламж, зээлийн хоршооны 10 тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн оролцсоноор сертификатаа гардан авлаа. Мөн Санхүүгийн зохицуулах хороо Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын “Ремакс” ХХК-ийн 40 гаруй ажилтнуудад Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүй, гүйлгээний хяналт, комплайнс сэдвээр сургалт зохион байгуулав.




ХЭРЭГЛЭГЧ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 133 өргөдөл, гомдол ирсэн байна.



Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбартай холбоотой өргөдлийн тоо болон ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоо өссөн байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 133 өргөдөл, гомдол ирснээс:

Хүснэгт. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	121
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	10
Хугацааг нь сунган хянагдаж буй	2

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоног уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлт хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 23 иргэн Хорооны цахим хаягаар хандсан байх ба үүнээс даатгалын чиглэлээр 1 үнэт цаасны чиглэлээр 9 мөн банк бус санхүүгийн байгууллагатай холбоотой 8 бусад 5 /ломбард, ТМАТ автомат машин, Анод банк гэх мэт/ асуудалд тухай бүр бүртгэл хөтлөн хариу өгч байгаа.

Дүрслэл. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

АЛИВАА КОМПАНИЙН ХЭТИЙН ХӨГЖИЛД КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛӨХ НЬ

Зөвхөн нээлттэй хувьцаат компани, эсхүл нэгэнт хөл дээрээ зогсож бизнес нь тодорхой хугацааны туршид үргэлжлэн тогтворжсон, олон хувьцаа эзэмшигчидтэй компани сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг, ингэснээр үр дүнг нь хүртдэг гэдэг нь өрөөсгөл ойлголт юм.

Бодит амьдрал дээр том, бага, зохион байгуулалтын хэлбэр, дөнгөж үүсгэн байгуулагдсан, эсхүл үйл ажиллагаа нь тогтворжсон гэх зэргээс үл хамааран бүх л компаниудын өрсөлдөж буй бизнесийн орчинд сайн засаглал нь чухал ач холбогдолтой байдаг. Бүх компаниудад тохирох нэгэн ижил бус харин тухайн компанийн онцлогт тохирсон зохистой засаглал нь түүний бизнесийн үйл ажиллагааны үр ашиг, удаан хугацаанд амжилттай оршин тогтноход шууд эергээр нөлөөлдөг аж.

Одоо ч зарим хүмүүсийн дунд компанийн засаглалын олон улсын зарчмууд нь зөвхөн онолын шинжтэй, тэдгээрийг нэвтрүүлснээр бизнесийн үзүүлэлтэд шууд нөлөөлдөггүй, тэдгээрийг хэрэгжүүлэх зардал өндөр, хүнд суртал /шийдвэр гаргалтыг удаашруулдаг/-ыг бий болгодог, жижиг компанид тохиромжгүй гэх зэрэг ташаа ойлголтууд байсаар байна.

Гэвч үнэн хэрэгтээ, хөрөнгө оруулалт татах, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулах, хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ, шаардлагыг хангах, компанийг хөгжлийн дараагийн шатанд бэлтгэх зэрэгт компанийн зохистой засаглал зайлшгүй шаардлагатай юм.

Компанийн засаглалын суурь: Түүнийг нэг мөр тогтоосон тодорхойлолт гэж үгүй. Өргөн утгаараа тэрээр компанийн бизнесийг удирдан явуулж, урт хугацаанд санхүүгийн, үйл ажиллагааны болон стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх хяналтын процесс, дадал ба бүтэц аж.

Компанийн засаглалын зорилго нь хүчтэй, оршин тогтнох болон өрсөлдөх чадвар бүхий компанийг бий болгоход чиглэгддэг ба зөвхөн нэг загвар, арга барилд баригдаад байдаггүй. Харин компанийн засаглалын бүтэц, загварын онцлог нь зарим нэгэн хүчин зүйлүүдээс хамаардаг байна. Тухайлбал:

- Тухайн бизнесийн мөн чанар;
- Компанийн хэмжээ ба хөгжлийн үе шат;
- Нөөцийн олдоц, хүртээмж;
- Хувьцаа эзэмшигчдийн хүлээлт;
- Эрх зүйн, зохицуулалтын орчин гэх мэт.

Ач холбогдол: Компанийн засаглалыг амжилттай хэрэгжүүлэгчид нь сайн засаглал болон хувьцааны удаан хугацааны үнэ цэнийн хооронд шууд хамаарал бий гэдэгт эргэлздэггүй ба сайн засаглалын бусад давуу талуудаас дурдвал тухайн компанид дараах нөхцөлүүд бүрддэг байна. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн үр дүн бүхий гүйцэтгэл;
- Хүчтэй дотоод хяналтын тогтолцоо /дотоод хяналт, комплайнс, дотоод аудит/;
- Эрсдэлийн удирдлага;
- Гүйцэтгэлийн үр дүн бүхий хяналт ба шинжилгээ.

САЙН ЗАСАГЛАЛЫН ТОП 5 ТУРШЛАГА

Засаглалын зөв арга хэлбэрүүд нь компанийн үйл ажиллагаанд удаан хугацааны туршид эергээр нөлөөлөх ба хууль тогтоомж болон хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээ, хүлээлтэнд нийцсэн байх шаардлагатай. Ингээд олон улсын засаглалын мэргэжилтнүүдээс хүлээн зөвшөөрөгдсөн компанийн сайн засаглалын дараах ТОП 5 туршлагыг танилцуулья.

1. Хүчтэй, мэргэшсэн ТУЗ-ийг бүрдүүлж, гүйцэтгэлийг нь үнэлэх: ТУЗ нь тухайн бизнесийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах зохих мэдлэг, дадлага, туршлага, ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй мөрддөг, мэргэшсэн, мөн өөрийн хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд цаг гаргадаг гишүүдээс бүрдэх ёстой. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?

- Одоогийн ТУЗ-ийн гишүүдийн ажил хэрэгч болон хувийн зан чанаруудын хүчтэй ба сул талыг онцгойлон анхаарч, аливаа хамтын хэлэлцүүлгийн үеэр тэдгээрийг харгалзан чухал шийдвэрийг гаргаж байх;
- Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн гишүүний сул орон тоог нөхөх тохиромжтой этгээдийн жагсаалтыг үргэлж хөтөлж байх;
- ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус байх;
- Гүйцэтгэх удирдлагын зөвлөмжийг үг дуугүй дагах бус, харин ч асуудлыг нөгөө өнцгөөс харж, босгодог, бие даасан мэргэшсэн хандлага бүхий ТУЗ-ийг бүрдүүлэх;
- ТУЗ-ийн гишүүдийг мэргэшүүлэх. Шинэ гишүүдэд компанийн бизнес, өөрсдийнх нь чиг үүрэг, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн хүлээлтийн талаар тодорхой мэдээллийг тогтмол өгч байх, ТУЗ-ийн хурлын дэгт бизнесийн ба засаглалын талаар байнгын сургалт явуулах хангалттай цаг оруулах;
- ТУЗ-ийн гүйцэтгэлийг байнга хянаж, гишүүд өөрийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх болон гишүүн бүрийн гүйцэтгэлийг тогтмол хугацаанд үнэлж, дүгнэлт гаргадаг байх.

2. Чиг үүрэг ба хариуцлагыг тодорхой болгох. Хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн дэргэдэх хороод, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлага хооронд явагдах мэдээлэл, тайлагналын сувгийг маш тодорхой болгон зааглах:

- Компанийн дүрэм, холбогдох журамд ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтан тус бүрийн эрх хэмжээ, хариуцлагыг нарийвчлан тусгах.
- Тодорхой үйлдэл, хэлцэл, эсхүл боломжийг үнэлж дүгнэлт гаргахаар байгуулагдсан аудит, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх, засаглал, эрсдэл, стратегийн гэх мэт хороодод ТУЗ-ийн зарим чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхээр шилжүүлж байх.
- ТУЗ болон түүний дэргэдэх хороо, ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх удирдлагын тус бүрийн ажлын чиг үүргийг журамлан баримтжуулах.

- ТУЗ-ийн дарга ба гүйцэтгэх захирлын ажлын чиг үүргийг зааглах /ТУЗ-ийн дарга компанийн урт хугацааны стратегийн зорилгыг хэрэгжүүлэх, ТУЗ-ийг удирдах, харин гүйцэтгэх захирал бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж, ТУЗ-д тайлагнах үндсэн чиг үүрэгтэй/.

3. Ёс зүйт шударга явдлыг онцлох: ТУЗ-ийн дарга, гишүүд нь сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ тухайгаа мэдэгдэх үүрэгтэйгээс гадна сонирхлын зөрчилтэй тохиолдолд санал хураалтад оролцохгүй байх, мөн хамгийн чухал нь бүх гишүүд шударга бизнес хийх хандлагын нийтлэг соёл, хууль тогтоомжийг хүндэтгэн дагаж мөрдөхөд оршино. Байгууллагад энэ соёлыг бүрдүүлэхэд:

- Эрх зүйн зохицуулалт, нийгмийн хэм хэмжээ, компанийн үйл ажиллагааны дотоод журам, нөхцөл шаардлага зөрчигдсөн тохиолдолд зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах, түүнийг баримтжуулах, мэдээлэгчийн нууцлалыг хангах асуудлыг зохицуулсан ашиг сонирхлын зөрчлийн талаарх бодлого, шударга бизнес эрхлэх кодексыг баталж мөрдөх.
- ТУЗ-ийн дэргэдэх холбогдох хороо нь ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг, хариуцлагатай байх зэрэг нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

4. Гүйцэтгэлийг үнэлэх, шагнал урамшуулах: ТУЗ нь:

- Өөрийн гишүүдийн хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй, мөн бусад нэр дэвшигчдийн сонирхлыг татахуйц цалин хөлс, шагнал урамшууллын хэмжээ, давтамжийг тогтоох.

- Эрх бүхий албан тушаалтнуудын зорилтот ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх хэмжүүрийг тогтоон тогтмол хугацаанд үнэлэх ба үг үнэлгээг цалин хөлстэй нь уялдуулах.
- Цалин урамшууллын бодлого, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих хараат бус гишүүдээс бүрдсэн цалин урамшууллын хороог байгуулах (компанийн үнэт цаасыг эзэмшүүлэх гэх мэт) зэрэг нь зохимжтой.

5. Эрсдэлийн үр дүнтэйгээр удирдах: Компани нь өөрийн санхүүгийн, үйл ажиллагааны, нэр хүндийн, экологийн, зах зээлийн болон эрх зүйн эрсдэлүүдээ тогтмол хугацаанд тодорхойлж, үнэлэх шаардлагатай:

- ТУЗ нь компанийг эрсдэл удирдах, даах чадвартай болгох үүрэг, хариуцлага бүхий бүтцийг бий болгох стратегийн зорилготой байна. Тэрээр гүйцэтгэх удирдлагаас хэрэгжүүлж буй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хэмжих, бууруулах, зайлсхийх болон эрсдэлийн хяналт, тайлагналд ашиглагддаг эрсдэлийн удирдлагын систем болон удирдлагын хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг тогтмол шалгаж байх үүрэгтэй.
- ТУЗ-ийн гишүүд компанид тулгарч буй болон үүсэж болох богино, урт удаан хугацаанд үргэлжлэх эрсдэлүүд, тэдгээрийн үр нөлөө, мөн чанарыг таньж мэдэх, ойлгох нь хамгийн чухал, ингэх ч үүргийг тэд хүлээдэг. Мөн тэдгээр нь гүйцэтгэх удирдлагын эрсдэлийн талаарх таамаглал бодит эсэх, компанийн эрсдэлийг удирдаж буй процессын үйл ажиллагаа зохих ёсоор явагдаж байгаад үргэлж шүүмжлэлтэй хандах чадвартай байх нь чухал.



ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд нийт **526** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Арилжаа эрхлэх 2	Тооцооны 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1
ХОМК 23	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 5	ХК 304
ҮЦК* 53	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх 59	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 24	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 33

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.




Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- 2020 оны 2 дугаар улиралд нийт 29.1 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 67.8 хувиар буурсан.
- Нийт арилжааны 2 хувийг ЗГҮЦ, 17.2 хувийг компанийн бонд, 80.8 хувийг хувьцаа тус тус эзэлж байна

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,576.3 нэгжээр буюу 22.0 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,680.6 нэгжээр буюу 17.2 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 635.9 нэгжээр буюу 7.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.






ХААБ-ээр нийт 162.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 361 тэрбум төгрөгөөр буюу 69.0 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд зөвхөн 4 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.




ХАА-н биржийн МАРИХ индекс

ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу МАРИХ 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 918,691.4 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54,687.0 нэгжээр өссөн.





1.2 ДААТГАЛЫН САЛБАР




ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 2 дугаар улиралд даатгалын гүнзгийрэлт 0.57 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.07 хувиар буурсан байна.




* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- 2020 оны 2 дугаар улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өсөж 359.2 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оны мөн үеэс 8 хувиар өсөж 293.9 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.1 хувиар буурч, 55.7 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор давхар даатгалын хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөж, 9.6 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 2 дугаар улиралд нийт 94.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 94.1 тэрбум төгрөг буюу 99.2 хувь, урт хугацааны даатгалын компани 0.7 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 24.8 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 1.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 2 дугаар улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.5 хувиар буурчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР



- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 2 дугаар улиралд 27.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 67.3 хувиар өсөж 1.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.



1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

- 2020 оны 2 дугаар улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 542 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 77 буюу 14.2 хувь нь орон нутагт, 465 буюу 85.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.7 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар, 94.3 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 2 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 329.0 тэрбум төгрөгөөр буюу 21.5 хувиар өсчээ.






НИЙТ ЗЭЭЛ


2020 оны 2 дугаар улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар буюу 210.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Зээлийн хүү: 2020 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.9 хувьд хүрч буурлаа.

2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.6 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.4 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.




97.6%



1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 256-д хүрч өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурлаа.
- ХЗХ-дын гишүүдийн тоо 2019 оны 2 дугаар улиралд 67,434 байсан бол 2020 оны 2 дугаар улиралд 7.1 хувиар өсөж 72,230-т хүрчээ.



АЖИЛЛАГСАД

770

ХЗХ-дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.1 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН

36,575


ЗЭЭЛДЭГЧ

35,385

ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ

НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ


- 2020 оны 2 дугаар улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өсөж 234.4 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 8.1 пунктээр буурчээ.



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ


Хөрөнгийн зах зээл

33Ү /их наяд төгрөг/




Дунджаар 2.54 их наяд төгрөгт хүрсэн.

ТОП-20 индекс




16,450.52 буюу өмнөх сарын дунджаас 330.22 индексээр өссөн.

MSE A индекс



7,964.05 буюу өмнөх сарын дунджаас 2.29 индексээр нэмэгдсэн.

MSE Б индекс



7,458.35 буюу өмнөх сарын дунджаас 116.73 индексээр өссөн.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, www.mse.mn

Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

58,461,665

Хоёрдогч хувьцааны арилжааны үнийн дүн

/тэрбум төгрөг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Биелсэн хэлцэл

133

Богцын нийт хэмжээ

68,139

Богцын нийт үнийн дүн

39.9

/тэрбум төгрөг/

Нэгж богцын дундаж үнэ

584,769

Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж, www.mse.mn

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2020 ОНЫ 8-Р САРЫН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭ

Ковид-19-ийн нөлөөлөл

Ковид-19 тахал нь Ойрх Дорнод ба Төв Азийн бүс нутагт тархсаар байгаа боловч бүсийн зарим улс орнуудад хязгаарлалтыг аажмаар сулруулж байна. Учир нь энэхүү бүс нутаг нь харьцангуй хатуу хориг арга хэмжээг цаг үед нь авч хурдан хариу үйлдэл үзүүлж буй юм. Үүнтэй холбоотой нас баралт тус бүс нутагт харьцангуй бага байна. Харин шаардлагатай хориг арга хэмжээ авсан нь эдийн засгийн үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлсөн. Европ болон баруун хэсэгтэй харьцуулахад Ойрх Дорнод ба Төв Азийн бүс нутагт ажлын байрны хөдөлгөөн буурч байна. Урьд нь цагдан хориг бодлого хэрэгжүүлж байсан бүс нутгийн орнууд аажмаар бодлогоо сулруулах хязгаарлалуудыг хийж эхэлсэн (Алжир, Бахрейн, Гүрж, Иран, Иордан, Казахстан, Киргизстан, Ливан, Пакистан, Саудын Араб, Тунис, АНЭУ, Узбекистан). Дэлхийн эдийн засгийн уналт нь худалдаа наймаа, хангамж болон аялал жуулчлалын тасалдал, мөнгөн гуйвуулгын уналт зэрэгт хүргэсэн. Одоогийн байдлаар тоон мэдээлэл хараахан гараагүй байгаа боловч өнгөрсөн хямралын үеэр тус бүс нутагт ажилгүйдлийн түвшин нь ихэвчлэн хамгийн бага байсан нь зарим талаар төрийн байгууллагуудын харьцангуй аюулгүй ажлын байр хангаж байсантай холбоотой байв.

Газрын тосны цочролд нэрвэгдсэн бүс нутаг хүнд байдалд оров. Газрын тос экспортлогч орнуудын байгууллага болон бусад томоохон газрын тос үйлдвэрлэгчид (ОПЕК +) 3, 4-р сард гэрээ байгуулснаар, АНУ-ын **занар** газрын тосны олборлолт (shale oil production) буурснаар мөн эдийн засаг дахин нээгдэх үед зах зээлийн хүлээлт сайжирсантай зэрэгцэн газрын тосны үнийг тогтворжуулж чадсанаар 2019 оны эцсээс хойш алдагдлын тал хувийг нөхсөн боловч Ковид-19-ийн өмнөх түвшнээс хамаагүй доогуур байна. Гэсэн хэдий ч ОПЕК + хэлэлцээрээс гарсан томоохон үйлдвэрлэлийн бууралт, газрын тосны үнэ буурсан зэрэг нь экспортод сөргөөр нөлөөлж байна. Эдгээр хүчин зүйлүүд нь 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хүлээгдэж байснаас илүү хүчтэй нөлөө үзүүлэхэд хүргэсэн бол дэлхийн сэргэлт сул байгаатай холбогдуулан нөхөн сэргээлт нь урьд өмнө тооцоолсноос удаан хийгдэх төлөвтэй байна. 3 дугаар сараас эхлэн ерөнхийдөө хөгжиж буй зах зээлээс хөрөнгийн урсгал гэнэтийн эргэлтэд орж энэ бүсэд 6 тэрбумаас 8 тэрбум ам.долларын багцын урсгал гарчээ. Бүс нутгийн өндөр зээлтэй улс орнууд (Саудын Араб, Катар, АНЭУ) зах зээлд нэвтрэх боломжийг хангаж чадсан бөгөөд сүүлийн саруудад олон улсын хөрөнгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүдийг хийж байгаа бол, Бахрейн, Египет зэрэг бага үнэлгээтэй үнэт цаас гаргагчид анхдагч зах зээл дээр үнэт цаасаа гаргах болов.

Эдийн засгийн өсөлт буурах төлөвтэй байна

Дотоод болон гадаад байдлыг харгалзан үзэж, бодлогын арга хэмжээ авч байгаа боловч Ойрх Дорнод ба Төв Азийн бүс нутгийн бодит ДНБ 2020 онд 4.7 хувиар буурах төлөвтэй байгаа нь 2020 оны 4-р сарын бүс нутгийн эдийн засгийн төлвөөс 2 пунктээр буурсан үзүүлэлт байна. Эдгээр өөрчлөлтүүд нь голчлон Ойрх Дорнод, Хойд Африк, Афганистан, Пакистан (MENAP)-ы бүс нутгаар явагдсан бөгөөд 2020 оны 4-р сартай харьцуулахад 2 пунктээр суларч магадгүй байгаа

нь газрын тос экспортлогчдын идэвх буурч байгааг харуулж байна. Эсрэгээрээ Кавказ, Төв Азийн бүс нутгийн өсөлт ердөө 0.5 пунктээр буурсан нь MENAP-тай харьцуулбал газрын тос олборлолтын хэмжээ буурсан нь зарим улс орны бодлогын талаар илүү хүчтэй хариу өгч байгааг харуулж байна. Зарим улсуудын өсөлтийн өөрчлөлтүүд нь хориг тусгаарлалт болон хөдөлгөөнтэй (mobility) холбоотой харагдаж байна. 2020 оны 4-р сараас хойш хамгийн чанга хязгаарлалттай болон ажлын байрны хөдөлгөөн хамгийн багатай улс орнуудын ДНБ-ий бодит үнэлгээ өндөр гарав (Кувейт, Киргизстан, Оман, Саудын Араб, АНЭУ).

Үйлдвэрлэл 2019 онд 2.6 хувиар өссөнтэй харьцуулахад 2020 онд дунджаар 13 хувиар буурах төлөвтэй байна. Эмзэг, зөрчилтэй улс орнуудын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2018-19 онуудад 2900 ам.доллараас 2020 онд 2000 орчим ам.доллар хүртэл буурч магадгүй гэж үзэж байна. Энэ бол одоо байгаа эдийн засаг, хүмүүнлэгийн бэрхшээлийг улам хурцатгах эрс бууралт бөгөөд ядуурлын түвшинг ихээр дээшлүүлэх юм.

Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн газрын тос экспортлогч орнуудын өсөлт

Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн орнуудын ДНБ 2020 онд -7.3 хувь, 2021 онд 3.9 хувьд хүрэх төлөвтэй байна. 2020 ба 2021 онуудын аль алинд нь гарсан томоохон бууралтууд тахал өвчинтэй холбоотой тусгаарлалтаас болон газрын тосны үнийн хэлбэлзлээс үүдэлтэй байна. Газрын тосны ДНБ-ий буурсан өөрчлөлт нь түүхий эдийн олборлолтоос хүлээгдэж байснаас огцом буурсан үзүүлэлтийг харуулж байгаа бөгөөд газрын тосны экспортын орлого 2019 онтой харьцуулахад 2020 онд 270 тэрбум ам.доллараар буурах төлөвтэй байна. Гэрийн хорионд байх журам болон Ковид-19-өөс сэргийлэх бусад арга хэмжээнүүдийг авснаар эдгээр орнуудын эдийн засагт газрын тосны нөлөөгөөр бус ДНБ нь буурч улмаар аялал жуулчлал, амралтын газар, сувилал, тээвэрлэлт, жижиглэн худалдааны салбар нь хүлээгдэж байснаас ихээхэн хэмжээний алдагдалд хүргээд байна.

Кавказ ба Төв Азийн бүс нутгийн төлөвт ДНБ нь 4-р сарын урьдчилсан мэдээтэй харьцуулахад 2020 онд бага зэрэг буурч (-1.5-аас -1 хувь), 2021 онд ялимгүй сэргэж (4.4-өөс 4.7 хувь) байхаар төсөөлж байна. Бүс нутгийн газрын тос экспортлогч орнууд 2020 онд мөн бага зэрэг бууралттай (-1.1-ээс -0.8 хувь) байх төлөвтэй байгаа ч, Ойрх Дорнод ба Төв Азийн бүс нутгийн газрын тос экспортлогчидтой харьцуулбал харьцангуй бага гарсан байна. Газрын тосны бус түүхий эдийн үйлдвэрлэгчид (Казахстан, Узбекистан) алтны үнийн өсөлтөөс ашиг хүртсэн ба Узбекистаны цаг агаарын таатай байдал болон үнийн чөлөөлөлт (price liberalization) нь хөдөө аж ахуйн гарцыг нэмэгдүүлэв.

Эрэлт сул байгаа нөхцөлд энэ бүс нутагт (жил бүрийн тавдугаар сард инфляци 56 хувь хүртэл өссөн Ливанаас бусад орнуудад) инфляци бага түвшинд байх төлөвтэй байна. Аялал жуулчлалын ашиглалт, мөнгөн гуйвуулгын орлого, газрын тосны нийлүүлэлт тасалдсан энэ үед урсгал дансны үлдэгдэл 2020 онд улам дордох төлөвтэй байна.

Бүс нутгийн газрын тос импортлогчдын дунд төсвийн тэнцэл 2019 онтой харьцуулахад 2020 онд доройтох төлөвтэй байна. Энэ хугацаанд Ойрх Дорнод ба Төв Азийн бүс нутаг дахь төсвийн үлдэгдэл ДНБ-ий 1.4 нэгж хувиар буурах төлөвтэй байгаа бол Кавказ ба Төв Азийн бүс нутгийн импортлогчдын дунд доройтсон байдал нь ДНБ-ий бараг 6 пунктээр илүү байгаа нь Гүрж, Киргизстан, Тажикстан дахь

Ковид-19-ийн бодлогын хариу үйлдлийг хүчтэй харуулж байна. Өсөн нэмэгдэж буй эдгээр алдагдал нь өрийн тогтвортой байдлын асуудлыг ихэсгэж байгаа тул өрийн ДНБ-ий түвшин одоогийн байдлаар Ойрх Дорнод ба Төв Азийн бүс нутгийн хувьд ДНБ-ий дунджаар 95 хувь, Кавказ ба Төв Азийн бүс нутгийн хувьд ДНБ-ий 61 хувьд хүрэх төлөвтэй байна.

Хүснэгт 1. Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн бүс: Эдийн засгийн сонгогдсон үзүүлэлтүүд, 2000–21 (ДНБ-ий хувь)

Дундаж	2000–16	2017	2018	2019	2020	2021
Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн бүс						
Бодит ДНБ (жилийн өсөлт)	4.6	2.1	1.5	0.5	-5.1	3.1
<i>үүнээс газрын тосгүй өсөлт</i>	5.5	2.9	2.2	2.2	-4.7	2.9
Урсгал дансны тэнцэл	7.4	-0.5	3.2	1.0	-5.4	-4.5
Төсвийн нийт тэнцэл	2.2	-5.7	-2.7	-4.0	-10.6	-8.7
Инфляци (жилийн дундаж; хувь)	7.0	7.0	9.3	7.9	8.3	8.9
Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн бүсийн газрын тос экспортлогч улсууд						
Бодит ДНБ (жилийн өсөлт)	4.8	1.2	0.1	-0.8	-7.3	3.9
<i>үүнээс газрын тосгүй өсөлт</i>	6.0	2.2	1.1	1.8	-6.8	3.5
Урсгал дансны тэнцэл	10.7	1.8	6.6	3.2	-5.4	-4.4
Төсвийн нийт тэнцэл	4.7	-5.3	-1.2	-2.9	-11.4	-9.1
Инфляци (жилийн дундаж; хувь)	6.9	3.6	8.7	7.6	7.2	8.3
GCC улсууд: Бахрейн, Кувейт, Оман, Катар, Саудын Араб, Арабын нэгдсэн Эмират улсууд						
Бодит ДНБ (жилийн өсөлт)	4.6	-0.4	2.0	0.5	-7.1	2.1
<i>үүнээс газрын тосгүй өсөлт</i>	6.4	1.9	2.0	2.4	-7.6	3.0
Урсгал дансны тэнцэл	14.2	2.8	8.6	5.6	-3.9	-2.9
Төсвийн нийт тэнцэл	7.4	-5.7	-1.6	-2.1	-10.5	-8.0
Инфляци (жилийн дундаж; хувь)	2.9	0.3	2.1	-1.4	1.3	3.2
Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн бүсийн газрын тос импортлогч улсууд						
Бодит ДНБ (жилийн өсөлт)	4.2	4.0	4.3	3.0	-1.1	1.8
Урсгал дансны тэнцэл	-2.4	-6.7	-6.4	-5.5	-5.2	-4.6
Төсвийн нийт тэнцэл	-5.8	-6.7	-6.9	-7.3	-8.7	-7.8
Инфляци (жилийн дундаж; хувь)	7.7	14.4	10.3	8.5	10.2	9.8
Араб: Алжир, Бахрейн, Джибути, Египет, Ирак, Иордан, Кувейт, Ливан, Ливи, Мавритани, Марокко, Оман, Катар, Саудын Араб, Сомали, Судан, Сири, Тунис, Арабын Нэгдсэн Эмират, Йемен						
Бодит ДНБ (жилийн өсөлт)	4.8	1.2	2.4	1.9	-5.7	3.5
<i>үүнээс газрын тосгүй өсөлт</i>	6.0	2.1	2.5	3.0	-5.2	3.0
Урсгал дансны тэнцэл	8.9	-0.9	3.8	1.4	-6.9	-5.9
Төсвийн нийт тэнцэл	3.1	-6.4	-2.4	-3.2	-11.1	-9.4
Инфляци (жилийн дундаж; хувь)	4.8	6.9	5.8	2.4	4.5	5.8


- Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн бүсийн газрын тос экспортлогч улсууд: Алжир, Бахрейн, Иран, Ирак, Кувейт, Ливи, Оман, Катар, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират, Йемен.
- Афганистан, Пакистан зэрэг Төв Ази ба Өмнөд Азийн бүсийн газрын тос импортлогч улсууд: Афганистан, Джибути, Египет, Иордан, Ливан, Мавритани, Марокко, Пакистан, Сомали, Судан, Сири, Тунис.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 8 дугаар сарын 19-ний өдөр

S&P 500 /^GSPC/


3,389.78 +7.79 (+0.23%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/

23,110.61 +59.53 (+0.26%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/

6,076.62 -50.82 (-0.83%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Dubai Financial Market General Index DFMGI:IND

2,232.26 +7.65 /+0.34%/



Эх сурвалж: www.Bloomberg.com



📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

☎ +976-51-264444

@ press@frc.mn

🌐 www.frc.mn

📘 Санхүүгийн зохицуулах хороо

🐦 @FRC_of_Mongolia